МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,109.008... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.07. Баасан. №179 (4549) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

Л.БОЛД: СОНГУУЛИЙН ДАРАА АЖ АХУЙН НЭГЖҮҮД РҮҮ ДАЙРАЛТ ХИЙХ ГЭЖ БАЙНА

II нүүрт

СПОРТ

ӨЗИЛ, САНЧЕС НАР ДОЛОО ХОНОГТ 250 МЯНГАН ФУНТ АВАХЫГ ХҮСЧ БАЙНА

VII нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## “Хар” машин үнэхээр “но”-той юу

О.УЯНГА

2012 оны сонгуулийн саналын хуудсыг “хар” машин буюу санал тоолох машинаар тоолсон. Анх удаа гараар бус дэвшилтэт технологи ашигласан нь энэ. Харин сонгуулийн дараа өнөөх “хар” машиныг “но”-той гэж үзээд, тухайн үед цөөнх болсон намынхан ам хуурайгүй л ярьж байлаа. Харин ялсан нь “Эд гараар тоолж луйвар хийдэг байсан. Машинаар тоолохоор үнэн зөв гарч, бид яллаа” гэх маягийн юм ярьж байсан нь санагдана. Тэгвэл 2016 оны сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж, 65 суудал авсан. Цагтаа “хар” машиныг шатааж хүртэл үзэж байсан намынхан өөрсдөө ч итгэмээргүй ялалт байгуулсныхаа дараа “но” энэ тэр гэж ярьсангүй.

**Үргэлжлэл нь II нүүрт**

ЗАНГИАГҮЙ УУЛЗАЛТ

# Ц.ЭЛБЭГДОРЖ: УЛСТӨРЧИЙН МЭДЭГДЭЛ СҮРЖИН БАЙХ ТУСМАА ХУДЛАА БАЙДАГ

Ж.ОТГОНМЯГМАР

*Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс санаачлан “Ерөнхийлөгч сэтгүүлчидтэй” уулзалтыг зохион байгууллаа. “Зангиагүй уулзалт”-ыг тоймлон хүргэж байна.*

### Ц.Нямдоржид “Эрдэнэт”–ийг, ард түмнийг бодсон үнэр ч байхгүй




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

-Би “Эрдэнэт” үйлдвэрийн тоос шороонд хутгалдаж явсан, ажилчин байсан хүн. Аравдугаар анги төгсөөд л тус үйлдвэрт ажилтнаар орж байлаа. 1990 онд анх удаа Эрдэнэтээс улс төрийн албанд сонгогдож байсан. Тиймээс “Эрдэнэт” үйлдвэрийн ард миний ямар нэгэн хувийн сонирхол байхгүй. Хатуу хэлэхэд нэг ч төгрөгийн сонирхол байхгүй. Харин тус үйлдвэр цаашаа сайн яваасай гэсэн л сонирхол байна. Гэхдээ Эрдэнэтийн асуудалд төрийн гурван өндөрлөгийн оролцоо бий гэх яриа гарсан. Би бол гурван томын оролцоо байсан гэдгийг мэдэхгүй байгаа. Надад “Эрдэнэт” үйлдвэрийн хувьцаа байгаа юу гэж асуулаа. Надад хувьцаа байхгүй.

“Эрдэнэт” үйлдвэрийн талаар гарсан өмнөх Сангийн сайдын тушаалыг хууль бус гэх яриа гараад байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# Ямашита Маморү: МОНГОЛД АКТУАР ТООЦООЛОЛ ХИЙХ МЭРГЭЖИЛТЭН ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Б.ДАВААХҮҮ

*Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Монгол Улсад хэрэгжүүлж буй “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” төслийн ахлах зөвлөх Ямашита Маморү манай оронд хүрэлцэн иржээ. Түүнтэй ярилцсанаа хүргэе.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

**-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх болжээ. Төсөл хэрэгжүүлэх болсон шалтгааны талаархи асуултаас ярилцлагаа эхлэе?**

-Монгол Улсын Нийгмийн даатгалын системийг Японтой харьцуулахад, харьцангуй эрт хэрэгжиж эхэлсэн байдаг.

**Үргэлжлэл нь V нүүрт**

# МЭДЭГДЭЛ

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙХ, ИМПОРТЛОХ, ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН АНХААРАЛД**

**ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ**

Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд төв, орон нутагт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийг 2016 оны аравдугаар сарын 17-21-ний өдрүүдэд түр хугацаагаар зогсоож байгааг мэдэгдье.

Иймд уул уурхайн үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангах үүднээс тэсэлгээний ажил хийж буй компаниудад тэсрэх материал, тэсэлгээний хэрэгслийн хангалтыг зохицуулж, дурдсан хугацаанд агуулахын харуул хамгаалалтыг чангатган хариуцлагатай ажиллахыг анхааруулж байна.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**




| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2263.00 | 2283.00 | ФУНТ | 2837.00 | 2943.00 | АМ.ДОЛЛАР | 2265.00 | 2282.00 | ФУНТ | 2858.00 | 2937.00 |
| ЕВРО | 2508.00 | 2582.00 | РУБЛЬ | 34.90 | 38.00 | ЕВРО | 2512.00 | 2581.00 | РУБЛЬ | 35.28 | 38.44 |
| ИЕН | 21.67 | 22.30 | ЮАНЬ | 337.00 | 341.80 | ИЕН | 21.65 | 22.31 | ЮАНЬ | 337.00 | 341.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Ж.ОТГОН

УИХ-ын өчигдрийн чуулган 52.6 хувийн ирцтэй эхэллээ. Чуулганаар хэлэлцэх асуудлын эхэнд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслийн нэгдэх хэлэлцүүлэг дуусч, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт шилжүүллээ. Хуулийн төслийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат танилцуулсан юм. Тэрбээр, "Төсвийн алдагдал төсвийн зарлага хэт давсан гэдгийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Л.БОЛД: СОНГУУЛИЙН ДАРАА АЖ АХУЙН НЭГЖҮҮД РҮҮ ДАЙРАЛТ ХИЙХ ГЭЖ БАЙНА

улсын байгууллагууд судалгаандаа дурдсан байна. Засгийн газар цаашид төсвөөс гадуурх аливаа зүйлд санхүүжилт хийхгүй байх бодлого баримтална. 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа "Оюутолгой", "Тавантолгой", "Тавантолгойн цахилгаан станц" гэх мэт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эдийн засгийн бодит өсөлт гурван хувь байхаар тооцсон. Ирэх 2017 онд шинээр татвар бий болгохгүй, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолсон. Мөн төрийн өмчит зарим компанийг хувьчлах асуудал яригдана" гэлээ.

Хэлэлцүүлгийн шатанд, УИХ-ын гишүүн О.Баасанхүү "2017 оны төсөвт орлого зарлагын зөрүү хэдэн их наяд байгаа вэ. Орлого яаж бий болгох вэ. ААН-ийн орлогын албан татварын 16.8 болон 17.2 заалт дээр тодорхой хариулт авмаар байна. Хоёрдугаарт, багш, эмч нарын 36 сарын тэтгэмжийг байхгүй болгосон гэж байсан ч дахиад оруулж ирлээ. Тэлэлтийг хэрхэн тооцоолж байгаа вэ" гэдгийг тодрууллаа. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат "Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх ганц гарц нь өр тавих явдал. Энэ байдлаараа яваад байвал бид төсвийн хямралд орох магадлалтай. Алдагдалтай байгаа 2.5 их наяд төгрөгийн хувьд эх үүсвэртэй зардлыг бага байлгах, алдагдлыг бууруулах чиглэл барьсан. Багш, эмч нарын тэтгэмж бол төсвийн зарлага талдаа орж байгаа" гэлээ. Харин УИХ-ын гишүүн Ж.Батзандан "Стэнд бай" хөтөлбөрт хамрагдах гээд байна гэсэн мэдээлэл авлаа. Валютын сан 300 сая ам.доллараас дээш мөнгө манайд өгөхгүй. Валютын сан хөтлөгдөөд цааш явах гээд байна уу. Валютын сантай тусгай гэрээ хэлэлцээр хийгээд явах уу. Тусгай сангуудын тухай Засгийн газар ямар байр суурь баримталж байгаа вэ. 2017 онд тусгай сантай холбоотой бодлого байна уу. Сайд бүрийн дэргэд гадаадын зээл тусламжийн хөтөлбөрүүд байна. Энд Засгийн газрын дүгнэлт хийсэн үү" гэсэн асуултуудад хариулт авахыг хүссэн. Үүний хариуд Ж.Эрдэнэбат "Засгийн газрын гол шийдвэрлэх ёстой асуудал бол өрийн асуудал. Зээлийн тусламжуудын хөтөлбөрийн хувьд одоогийн байгаа байдлаас дордуулахгүйгээр энэ нөхцөлөөс сайжруулах тал дээр ажиллаж байна. Олон улсын валютын сангийн тухайд Б.Чойжилсүрэн сайд Олон улсын валютын сангийн намрын уулзалтад л очиж суусан. Энэ сард Олон улсын валютын сангийн ажлын хэсэг Монголд ирж эдийн засгийн нөхцөл байдалд дүгнэлт хийж ажиллана. Тэрхүү дүгнэлтийн дараа тусламж авах эсэхээ шийдвэрлэнэ" гэсэн хариултыг өглөө. Энэ үеэр УИХ-ын гишүүн Л.Болд "Засгийн газар өмнө нь татвар нэмэх хэвээр байгаа гэж мэдэгдэл хийж байсан. Гэтэл өнөөдөр татвар нэмэхгүй байхаар болсон гэж мэдэгдлээ. Тун удахгүй орон нутгийн сонгууль болно. Тиймээс хэсэг хугацаанд аж ахуйн нэгжээ хуурч байгаад сонгуулийн дараа аж ахуйн нэгжүүд рүү дайралт хийх гэж байгаа бол буруу улс төр болно шүү. Сонгууль болгонд зориулж хадны мангаа бий болгодог зүйлээ боль. УИХ-ын сонгуулийн өмнө "Эрдэнэт"-ийг идчихлээ гэж хэлээд танай нам олон тойргийг өөрийн болгосон. Одоо яагаад "Эрдэнэт"-ийн талаар мэдээлэл өгөхгүй байгаа юм бэ. УИХ-ын сонгуулиас хойш дөрвөн сар өнгөрчихлөө. Яагаад өнөөдрийг хүртэл энэ асуудлыг нэг тийш болгоод шийдчихэж болохгүй байгаа юм бэ? Хэн хулгайчийг бариарай гэж орилдог билээ. Түүн шиг юм болох гээд байгаа юм биш үү" хэмээн бухимдсан юм. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат "Татвар нэмэх асуудал өмнөх төсвийн тодотголын үеэр яригдаж байсан асуудал. Гэхдээ татвар нэмэхдээ нийтийг хамарсан татвар нэмнэ гэж яриагүй. Тухайн үед МАН-ын бүлэг дээр ярьж байгаад "Хойшлуулах нь зүйтэй" гэж шийдсэн. Жижиг болон дунд бизнес эрхэлж байгаа аж ахуй нэгжээс татвар авах шаардлага байхгүй. Өнөөдөр яагаад татвар нэмэх асуудлыг оруулж ирээгүй вэ гэхээр аж ахуй нэгжүүд хүнд байдалд байна. Тиймээс татвар нэмэх асуудлыг оруулж ирээгүй. "Эрдэнэт"-тэй холбоотой асуудал дээр бол бид ил болгосон. Тухайлбал, өмнөх Сангийн сайдын шийдвэрийг Засгийн газар хүчингүй болгосон. Ингэснээр төр өөрийн эрх мэдлийн 51 хувийг хариуцаад явна" гэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр сэтгүүлчидтэй "Зангиагүй уулзалт" хийсэн. Тэрбээр энэ үеэр УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн өнгөрсөн долоо хоногт хийсэн мэдэгдлийг шүүмжилсэн юм. Ерөнхийлөгч УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийг улс төрийн шоу хийж, эх орон болон "Эрдэнэт"-ийг бодолгүй сүржин мэдэгдэл хийсэн хэмээгээд улстөржилгүй ажлаа хийхийг сануулсан. Харин УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж өчигдөр УИХ-ын чуулганы үеэр өөрийн байр сууриа илэрхийлээд авлаа. Тэрбээр "Би УИХ-ын гишүүнийхээ хувьд төрийн байгууллагаас мэдээлэл авч, асуудал дэвшүүлэх эрхтэй. Энэ эрхийнхээ дагуу "Эрдэнэт" үйлдвэрийн талаар татвар болон бусад газруудаас мэдээлэл авсан. Намайг бараг Б.Чойжилсүрэнтэй хуйвалдчихлаа гээд Ц.Элбэгдорж өнөөдөр /өчигдөр/ юм ярьчихсан юм аа даа. Би Б.Чойжилсүрэнтэй хуйвалдаад 49 хувийг нь авчихсан юм уу хаашаа юм. Энэ одоо юу яриад байгаа юм. Энэ асуудлаар надад Засгийн газарт ч байхгүй мэдээлэл байна. "Эрдэнэт"-ийн 49 хувийг худалдаж авах үйл ажиллагаа зохион байгуулсан хүн нь Ц.Элбэгдорж өөрөө. Зургадугаар сарын 29-нд Ташкентад гурван улсын уулзалт болоход ХХБ-ны О.Орхон нь өөрөө очиж, эцсийн цэг тавьсан. Би үүнийг л хэлсэн юм. Одоо мэдэн будилад байж хэрэггүй. "Эрдэнэт"-ийн татвар төлөлтийн байдлыг намын бүлэгт гаргаж өгсөн мэдээлэл байна. Наймдугаар сарын байдлаар улсын төсөвт 20 тэрбум төгрөг оруулсан байсан юм. Есдүгээр сарын байдлаар "Эрдэнэт" үйлдвэр 54 тэрбум төгрөгийн татвар оруулсан байна гэж ТЕГ тайлан гаргаж өгсөн байна. Өнгөрсөн жил 323 тэрбум төгрөгийн татвар төлж байсан юм. Тэгээд "Эрдэнэт"-тэй адилхан үйл ажиллагаа явуулж буй "Оюу толгой" есдүгээр сарын мэдээгээр улсад 278 тэрбум төгрөг татварт төлчихсөн байна. Өнгөрсөн жил Оюутолгой 140 тэрбумыг төлсөн. Энэ жил дахиад 278 тэрбумыг төлчихөөд байна. 278 тэрбум 54 тэрбумын хооронд асар их зөрүү байгаа биз. Одоо энэ бүлэглэл дамжсан луйвраа хамгаалах хэрэггүй. Гэхдээ хамгаалахын тулд их ажил хийх юм шиг байна" хэмээн хариу өгөөд амжсан юм.

УИХ-ын чуулган үдээс хойш 15.00 цагт хуралдах ёстой байсан ч дугаар шилжих мөчид хуралдаж эхлээгүй байсан юм. Учир нь УИХ-ын олонхийг бүрдүүлдэг МАН-ын бүлэг Төрийн ордонд хуралдаж байсан учир чуулганы хуралдаан ийнхүү хойшилжээ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

# Ж.БАТСУУРЬ: Оюутнууд сургалтын зээл авах боломжтой боллоо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*Засгийн газрын ээлжит хуралдаанаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Сургалтын төрийн сангийн чиг үүргийг өргөжүүлж, "Боловсролын зээлийн сан" болгон өөрчлөх, орон тоо, цалингийн санг баталж хэрэгжүүлэхийг сайд Ж.Батсуурь, Б.Чойжилсүрэн нарт даалгалаа. Мөн "Оюутны хөгжлийн зээл"-ийн журмыг баталаад байна. Энэ талаарТөрийн ордонд БСШУС-ын сайд Ж.Батсууриас тодрууллаа.*

**-Засгийн газрын ээлжит хуралдаанаас хэд, хэдэн чухал шийдвэрийг гаргажээ. Энэ талаар тодруулахгүй юу?**

-Засгийн газрын ээлжит хуралдаанхуралдаж,МонголУлсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан боловсролын салбарын зорилтуудыг хэрэгжүүлэх хэд, хэдэн чухал шийдвэрийг гаргалаа. Нэгдүгээрт, "Оюутны хөгжлийн зээл" олгох харилцааг зохицуулсан журмыг баталсан. Хоёрдугаарт, гурав ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд суралцаж байгаа тохиолдолд нэг хүүхдийнх нь сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг олгохоор болсон. Ойролцоогоор улсын хэмжээнд 1500 орчим оюутанд энэхүү буцалтгүй тусламжийг олгох урдчилсан тооцоо байна. Гуравдугаарт, "Боловсролын зээлийн сан"-г байгуулж, түүгээр дамжуулан "Оюутны хөгжлийн зээл" олгох ажлыг арилжааны банк зохион байгуулна.

**-Ямар нөхцөл, шалгуураар "Оюутны хөгжлийн зээл" олгох вэ?**

-Бага хүүтэй, суралцагч сургуулиа төгсч, ажилтай, орлоготой болсон цагаасаа эргүүлж төлөх бололцоог хангасан, туйлын тааламжтай нөхцөлтэй, хөнгөлөлттэй зээл авах харилцааг зохицуулсан журам Засгийн газрын хуралдаанаар батлагдлаа. "Оюутны хөгжлийн зээл" нь гурван үндсэн төрөлтэй. Нэгдүгээрт нь, хүү бууруулах зээл, хоёрдугаарт богино хугацаатай зээл, гуравдугаарт урт хугацаатай зээл гэсэн гурван төрлийн хэлбэр байгаа. Арилжааны банкуудаас сургалтын төлбөрийн зориулалтаар цалин, тэтгэврийн зээл авсан оюутан, суралцагсад хүү бууруулах зээлд хамрагдах боломжтой. Өөрөөр хэлбэл, өндөр хүүтэй авсан зээлээ "Оюутны хөгжлийн зээл" рүү шилжүүлж боломж нь хангагдаж байна. Харин богино хугацаатай зээлийн хувьд нэг жил. Урт хугацаатай зээлийн хувьд 10 хүртлэх жил байхаар тооцоолсон. Суралцагсдын сурлагын голч дүн гурав байх, нэн хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж байгаа бол голч дүн 2.5 байхаар тогтсон. Шинээр элсэгчдийн хувьд ЭЕШ-д 400-аас багагүй оноотой буюу их, дээд сургуульд элсэн суралцах босгыг хангасан байх, үргэлжлүүлэн суралцагсдын хувьд голч дүн хоёроос доошгүй байх гэсэн ерөнхий шалгууртай. Өөрөөр хэлбэл, тухайн суралцагч 50 хувийн амжилттай суралцахад л энэхүү зээлд хамрагдах эрх нь үүсэх юм. Мөн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн оюутан байх гэсэн нэг шалгуур бий. Монгол Улсын хэмжээнд бакалаврт суралцаж буй 125 мянган оюутан бий. Нийт оюутнуудын 49 хувь буюу 74 мянга орчим нь сургалтын төлбөрөө төлж чадахгүй, сургалтын төлбөрийн үлдэгдэлтэй байсан. Тиймээс ч энэ хэрэгцээн дээр үндэслэж оюутнуудад сургалтын төлбөрийн зээл зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

**-Зээлийг аравдугаар сараас олгож эхэлнэ гэсэн байсан. Арилжааны банкаар дамжуулж олгох уу?**

-Арилжааны банкуудын хувьд "Оюутны хөгжлийн зээл"-ийг зохион байгуулах хүсэлтээ гаргаж, нөхцлийг хүлээн зөвшөөрч, "Боловсролын зээлийн сан"-тай гэрээ байгуулан ажилласнаар зээл олгох нөхцөл нь бүрдэнэ. Жилийн 5 хувийн хүү гэдэг бол арилжааны банкуудаас олгож буй зээлийн хамгийн бага хүү. Ер нь цалин, тэтгэврийн зээлийн жилийн хүү 20-25 хувь байдаг. Тэгэхээр "Оюутны хөгжлийн зээл" бол хамгийн таатай нөхцөлтэй, дарамтгүй зээлийн хэлбэр гэж бид үзэж байна. Тухайн суралцагч төгссөнөөсөө хойш 3-4 жилийн хугацаанд зээлээ төлж дуусгах боломжтой. Энэ зээлийг хөгжлийн гэж тодотгосны учир нь нэгдүгээрт оюутан бүрт зээл авах бүрэн бололцоог нээж өгсөн, хоёрдугаарт нэн тааламжтай нөхцөлтэй гэж үзэж байгаа, нөгөөтэйгүүр оюутнуудад ямар нэгэн төлбөрийн дарамтгүй суралцах боломжийг нээж өгөхийн зэрэгцээ, өрхийн амжиргааны зардлыг бууруулах, амьдрах чадамжийг дээшлүүлээд онцгой ач холбогдолтой. Эргээд эдийн засагт оруулж буй үр өгөөжтэй шийдвэр гэж харж байна. Учир нь эдийн засгийн оновчтой бүтцийг бий болгох, хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний зохистой харилцааг бүрдүүлэхэд зээлийн үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Зээлийг хэзээнээс олгож эхлэх вэ гэхээр Засгийн газар журам албажих процессын хугацаа байдаг. Үүний дараа энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх Сангийн сайд, БСШУС нарын хамтарсан тушаал гарна. Ер нь энэ сардаа багтааж арилжааны банкуудтай гэрээ байгуулснаар зээл олгох нөхцөл нь бүрдэнэ. Цаг хугацааны хувьд ойрын хугацаанд буюу энэ сардаа багтааж "Оюутны хөгжлийн зээл" олгож эхлэхээр ажиллаж байна. Нэг зүйлийг тодруулж хэлэхэд "Оюутны хөгжлийн зээл"-д зөвхөн бакалаврын сургалтад суралцаж байгаа оюутнуудад олгоно.

**-Зээлд зориулж улсын төсөвт хэдэн төгрөг тусгасан бэ?**

-Энэ оны төсвийн тодотголоор 90 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг баталсан. Ирэх оны төсөвт 100 тэрбум төгрөгийг тусгасан. Эхний гурван жилдээ "Боловсролын сан" улсын төсвөөс эх үүсвэрээ бүрдүүлнэ. Түүнээс хойш буюу 4, 5 дахь жилээсээ зээлийн эргэн төлөлтөөр мөнгөн эх үүсвэрээ хуримтлуулах боломжтой гэж харж байгаа.

Дугаарын 60 мөр

## "Хар" машин үнэхээр "но"-той юу

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Харин ялагдсан талынхан, жижиг намууд аанай л өнөөх машиныг ярьж, муу хэлсээр байгаа. Бүр янз бүрээр л хардаж байна. Өнөөх муу нэртэй "хар" машин чинь үнэхээр "но"-той гэнэ ээ. Бүр программыг нь засчихдаг юм байх. Тэгж засч чаддаг хоёр, гурван хүн байгаа бөгөөд бүгд өндөр албан тушаалд очиж суугаад, жаргаж байгаа гэсэн цуурхал ч байна. Хамгийн гол нь программыг янзалж, өөртөө ашигтай байдлаар эргүүлэхийн тулд багагүй хэмжээний мөнгө хэн нэгэнд төлөх ёстой юм уу даа, янз нь. Гэтэл энэ удаагийн сонгуулиар АН мөнгөө төлөөгүй, МАН өгчихсөн гэнэ. Тэгээд л МАН-ынхан ялчихгүй юу. Иймэрхүү явган яриа ч бас гарч л байна. Ямар ч байсан өнөөх хар машиныг яаж ийж байгаад л "но"-той болгох гэж оролдоод байгаа бололтой юм. Хөөрхий, үнэхээр "но"-той юм болов уу даа. Ингэж хардаж байхаар бүр халаад хаявал таарна. Тэгээд гараараа тоолоод л явж байхгүй юу, хуучин шигээ. Гараар гэснээс, сая сонгуулиар ч гэсэн хяналтын тооллого хийсэн. Тэгээд яав, үр дүн өөрчлөгдсөн юм байхгүй. Хэвээрээ л гарсан. Тэгэхээр үнэхээр "хар" машин "но"-той байсан бол гараар тоолоход зөрмөөр санагдах юм. Ингээд бодохоор тэр "но" энэ тэр нь худлаа ч байж магадгүй. Гэтэл бас энд тэнд ганц нэг доголдол гарсан байх магадлалтай гэсэн явган яриа гараад байна. Одоо орон нутгийн сонгуулийн өмнө хаа сайгүй л өнөөх муу нэртийг янз бүрээр шалгаж үзэх гээд байгаа бололтой юм. Гэхдээ МАН үнэхээр УИХ-ын сонгуулийн үеэр өөрийн намын нэр дэвшигчийн төлөө тоолдог болгоод "хар" машиныг "найрчихсан" бол шалгаад ч нэмэргүй биз дээ. Ер нь МАН орон нутгийн сонгуулийн өмнө сурталчилгаа бараг хийхгүй байгаа. Онц ач холбогдол ч өгөхгүй, хэвлэлээр ч сурталчилгаа хийхгүй гэсэн гэнэ билээ. Нэр дэвшигчид нь хэдэн самбар гаргаж тавиад л гүйцээ. Харин намын дарга нь өөрөө хөдөө, орон нутгаар жаахан явж, улсын ажил болоод сонгуулийг зэрэг ярьж, иргэдтэй уулзаж байна. Ийн хэвлэлийг хаяад байгаа нь тэд ялалтдаа итгэлтэй байгаагаас болж байж ч болох. Тэртэй тэргүй хэний ч төлөө дугуйлсан машин МАН-ын төлөө тоолоод гаргачих юм чинь гээд. Өнөөх мөнгө төлж программ уншуулжээ гэх яриа ортой ч байж болох талтай гэж хардаад байгаа хэрэг. Эсвэл тэртэй тэргүй намын рейтинг уначихсан юм чинь буянаараа л бологгээд бас хаяж байж ч болох л доо. Хэрвээ МАН орон нутагт ч цөм ялбал энэ яриа улам л газар авах байх. Тэд программ уншуулсан нь батлагдлаа гэж ирээд л ярьж гарна биз. Харин АН юм уу, бусад хүчин орон нутагт ялчихвал яах юм бол. "Хар" машин гэж, зовлонтой ч эд юм даа, хөөрхий.

# ҮЗЭЛ БОДОЛ

ЗАНГИАГҮЙ УУЛЗАЛТ

# Ц.ЭЛБЭГДОРЖ: УЛСТӨРЧИЙН МЭДЭГДЭЛ СҮРЖИН БАЙХ ТУСМАА ХУДЛАА БАЙДАГ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгэхээр би энэ бүгдийг яриад байгаа хүн болон УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн мэдэгдлийн ард "Эрдэнэт"-ийг, ард түмнийг бодсон үнэр ч байхгүй гэдгийг хэлмээр байна. Харин энэ мэдэгдлийн ард "Эрдэнэт"-ийн үйл явдлыг шалгах гэж байгаа ажлын хэсгийн ахлагч, Ц.Нямдоржтой хуйвалдсан байдал харагдаад байгаа. Би наадмын өмнө Үндэсний телевизээр ярилцлага өгч байхдаа "Эрдэнэт" дээр хууль бус ямар нэгэн асуудал байгаа бол шинэ Засгийн газар, УИХ ажлын эхний өдрөөсөө авч хэлэлцээрэй" гэж хэлж байсан. Гэтэл долдугаар сард Сангийн сайд томилогдсон. Өмнөх Сангийн сайдынхаа тушаалыг тухайн үедээ л хүчингүй болгох боломжтой байсан. Хэрвээ буруу байсан бол хүчингүй болгох ёстой. Яагаад би Б.Чойжилсүрэн, Ц.Нямдорж хоёрыг хуйвалдсан байж магадгүй гээд байна гэхээр хууль бус зүйл хийхэд бололцоо олгосон байгаа юм. Тэд зүгээр л цаг хүйтрэхийг, улс төрийн улирал халахыг, аравдугаар сар эхлэхийг хүлээсэн байна. Тэгээд Ц.Нямдоржийг мэдэгдэл хийхэд ажлын хэсгийн ахлагч нь материал цуглуулж өгөх ажил хийсэн байх нь. Цуглуулсан материал нь юу байсан гэдгийг та бүхэн бүгд сонссон. Эхнээсээ няцаагдаад явж байна. Тэгэхээр энэ бол цэвэр улс төр. Ер нь улс төрийн болон улстөрчийн мэдэгдэл сүржин байх тусмаа худлаа байдаг. Тухайлбал, "Би сүхэн дор толгойгоо тавьж байна, мафи гарлаа, сүүлчийн цамцаа урагдтал би тэмцэнэ, надад МАН, Засгийн газар ямар ч хамаагүй" гэх мэтээр сүржин мэдэгдэл хийсэн. Ер нь Ц.Нямдорж намаа тэгж хэлэх хүн мөн үү. Зүгээр л хувийн эрх ашиг хөөцөлдсөн, дээд талынхаа суудал руу мяраасан мэдэгдэл хийлээ.

## Хойд хөршдөө баярлалаа

"Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувь Монголд ирлээ. Тиймээс ч ОХУ-ын байр суурь ямар байгаа талаар сонирхож байх шиг байна. Бид чинь хоёр том хөрштэй. Гэтэл оросууд ингээд "Эрдэнэт"-ийг монголчуудад 49 хувийг өгч байгаа нь стратегийн сонирхлоосоо татгалзаж байгаа юм биш биз гэсэн зүйлийг яриад байна. Өнгөрсөн зургадугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгч Путинээс Шанхайн хамтын ажиллагааны дээд төвшний уулзалтад оролцож байхдаа би шууд асууж байсан. Тэгэхэд Ерөнхийлөгч Путин надад "Өө энэ асуудлыг би мэдэж байгаа. Монголчууд өөрсдөө энэ үйлдвэрээ аваад явж чадна гэдэгт би итгэж байгаа" гэж хэлсэн. Ер нь ингэж асуудлыг шийдэж байгаа нь хоёр орны дээд төвшний харилцан итгэлцэл хамгийн сайн үедээ байгааг харуулж байгаа юм. ОХУ-ын Ерөнхий сайд Дмитрий Медведев сая АСЕМ-ын уулзалтад ирсэн. Тухайн үед энэ асуудал хөндөгдөхөд "Бид олон шинэ төслүүд дээр хамтарч ажиллах боломж үүгээр нээгдэж байна гэж харж байгаа" гэж хэлж байсан. Нөгөө их өрийн гээд яригдаад байдаг асуудлын сүүлчийн төлбөр 2016 оны эхний улиралд шийдэгдсэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх. Тэгэхээр Монгол Улс санхүүгийн, дэд бүтцийн, уул уурхайн, эдийн засгийн, хүмүүнлэгийн, хөрөнгө оруулалтын салбарт хойд хөрштэйгөө ажиллах бүрэн боломж бий. Улс төрийн хувьд манай хоёр орны харилцаа хамгийн өндөр дээд төвшинд байна. Ер нь бид ОХУ-ын өнөөгийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, төрийн дум, холбооны зөвлөлд ажиллаж байгаа хүмүүст болон хойд хөршдөө баярлалаа гэж хэлэх ёстой. Биднэд итгэж, хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжууд байгаа гэж харж байгаад баярлах ёстой юм. Монгол, Оросын ард түмний харилцаа гайхамшигтай түүхтэй. Монголын ард түмний төлөө цусаа урсгаж явсан ард түмэн Орос. Бүтээн байгуулалтад хөлсөө дуслуулж явсан улс Орос. Ямар улстай хамгийн ойрхон ажиллах вэ гэхэд 60 гаруй хувь нь ОХУ-тай ойрхон ажиллах ёстой гэж хариулдаг. Бүх яамд, салбарын төвшинд хамтарч ажиллах байх, өмнөх уламжлалаа үргэлжлүүлэх байх гэж харж байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ОХУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай 10 гаруй удаа уулзсан. Өмнөх түүхийг харахаар хоёр жилд нэг удаа ч уулзаагүй тохиолдол бий. Харилцаа өндөр төвшинд хүрсэн, хойд хөршийн удирдагчид хоёр орны харилцаа ямар чухал юм бэ гэж үздэгийн илэрхийлэл. Хоёр орны хооронд иргэд визгүй зорчдог болоод хоёр жил болж байна. Урагшаа явсаар нэг хотыг манай иргэд хөгжүүлсэн гэж ярьдаг. Хойд хөршийн маш олон иргэн Монголд орж ирдэг болсон, тэндээс хамтын ажиллагаа эхэлж байна. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хооронд харилцаа эрчимтэй явж байгаа. Хоёр хөршийнхөө төрийн тэргүүнтэй яагаад уулзаж болдоггүй юм бэ гэж санал гаргаад уулздаг болсон. Гурван улс оролцоод 36 төсөл хэрэгжүүлэх боломжтой гэж жагсаалт гаргасан. Ойлголцсон жагсаалт. Нэг зүйлийг би хүсэж байсан, төмөр замыг хос болгочих юмсан гэж. Урд хөрш маш том үйлдвэрлэгч. Орос, Хятадын хооронд бүх ачаа бараа Монголоор дайрч өнгөрдөг болох юмсан гэсэн итгэлцлийг бий болгохсон гэж ажилласан. Цаашаа энэ ажил хийгдэх байх гэж итгэж байгаа.

## Төрийн албан хаагчид өглөө бүхэн ажилдаа айдастай очиж байна

Хамгийн гол зүйл нь Засгийн газар байгуулагдаад 100 хоног өнгөрлөө. Б.Чойжилсүрэн болон Ц.Нямдорж юу хийв. Уг нь Сангийн сайдын хувь хамгийн гол асуудлыг оруулж ирээд, шийдүүлсэн байх ёстой байсан. Гэтэл өнөөдөр ярих юм юу ч байхгүй. Ярих гэхээр л зогсоосон, хассан, боосон, танасан зүйл байхаас бүтээсэн зүйл нэг ч байхгүй байна. Тиймээс юу ч хийгээгүй учир хүмүүсийн анхаарлыг энэ асуудлаас холдуулах гэж "Эрдэнэт"-ийг яриад байгаа юм. Тухайлбал, 70 жил, дээр нь нээлттэй нийгэмд шилжсэн 26 жил Монголын ард түмний хөлс, цус, нулимсаар туршигдсан хар тоглолцоог халах гэж баталсан Эрүүгийн болон Зөрчлийн таван хуулийг оруулж ирсэн байсан. УИХ нь баталчихсан Монголын ард түмний нурууг тэнийлгэх таван хуулийг буцаагаад хаячихсан.

Хэрвээ Ц.Нямдорж "Эрдэнэт" үйлдвэрийн асуудлыг яриагүй бол эхний сэтгүүлч уулзаад л "Баталчихсан байсан таван хуулийг яагаад буцаачихсан юм. Та өмнө нь Хууль зүйн сайд байсан хүн" гээд л асуух байсан. Тэгвэл Ц.Нямдорж "Одоо сонгогчид надтай уулзахад би "Эрдэнэт"-ийн аврагчийн дүрээр харагдана" гэж л тооцсон. Гэтэл эд нартай ярих, нэхэх олон зүйл байгаа. 36 сарын тэтгэмж, хүүхэд харах үйлчилгээ, ахмадуудын асуудал, төрийн албан хаагчдыг ажлаас халах гээд олон асуудлаас хүмүүсийн анхаарлыг холдуулж байгаа юм. Сүүлийн үед хүмүүс надад ажлаас халж байгаа асуудлыг маш их хэлж, ярьж байгаа. Бүр төрийн албан хаагчид гасалж байна. Өглөө бүхэн ажилдаа айдастай очиж байна. Учир нь "чамайг ажлаас халлаа" гэж хэлэх байх гэж айдаг болсон гэнэ. Яагаад ингэж айдастай очиж байна гэхээр бүх хүн машины, байрны зээлтэй байгаа шүү дээ. Бүр коммунист суботник шиг болчихлоо гээд байна. МАН-ынхан энэ асуудал дээр анхаараарай гэж дээд төвшиндөө хэлж байгаа байх. Зарим газар бүр зөвхөн дарга гэхгүй бүр мэргэжилтэн цэвэрлэгч гээд хэнийг ч голохгүй нэрсийг нь жагсааж байгаад, тэдэн оноос хойш ажилд авсаныг нь гэж хугацаа зааж байгаад толгой дараалан хөөж, явуулаад шахааны хүмүүсийг оруулж ирж байна. Ийм байж болохгүй ээ. МАН-ын зарим удирдлагууд гээд нэрийг нь надад хэлж байсан. Ц.Нямдорж мэдэгдэл хийснээс болсон уу яасан. Тэр хүний гар, хөл хүрээгүй газар алга боллоо. Энэ нөхрийн шахдаг бүлэглэл банк санхүүгээс эхлээд олон салбарыг бүхэлд нь ээлчихлээ гэх зэргээр мэдээлэл ирдэг. Уг нь энэ мэт зүйлийг Ц.Нямдоржоос асуух ёстой.



> ...Банктай холбоотой асуудлыг чөлөөлөх, хоёр дахь зах зээлийг бий болгох. Хувийн аж ахуйн нэгжүүд нэг хүний өмч байхаа больё, Монголын ард түмэнд хувьцаагаа зар, Засгийн газар, УИХ-ын зүгээс ажлаа хий, хуулиа батал. Засгийн газар төсвөө оруулаад ирдэг, УИХ нь дураараа тэлж байдаг, батлсны дараа дандаа тодотгож байдаг...

Засгийн газрын 100 хоног болох гэж байна. Би Б.Чойжилсүрэн сайд томилогдсоны дараа түүнтэй нэг л удаа уулзсан. Б.Чойжилсүрэн сайд энэ нь ч, тэр нь ч буруу гэж хэлээд зогсоогоод байвал зогсоогоод байж болно. Энэ хүн бүтээн байгуулдаг, барилга барих талдаа сайн. Харин Сангийн сайдын хувьд ямар хүн бэ. Энэ хүнээс илүү мэргэжлийн хүн буюу сайн Сангийн сайд болох хүн МАН-д байсан уу гэдэг бол асуудал. Шууд хэлэхэд Ц.Нямдоржийн шахаа энэ Сангийн сайдыг бий болгосон байж магадгүй л юм. Хүмүүс хоорондоо яриад л байгаа. Иймэрхүү маягаар албан тушаалыг хоорондоо хувааж авдаг, хуйвалддаг байдлаар улс төр хийдэг ээ л болих хэрэгтэй. Сонгуулийн өмнөхөөс амьдрал сайжрав уу гэхээр бүх хүн "бүр дордлоо" гэж байна. Ийм зүйлээс бултах гэж чанга, чанга мэдэгдэл хийгээд байх шаардлагагүй. Одоо бол мэдэгдэл хийдэг цаг биш ажил хийдэг цаг. Нэгдээд нийлээд ажилламаар байгаа юм. Одоо сонгууль дууссан, нэгдээд нийлээд ажиллая. Хагаралдах үйл явц хангалттай болсон, одоо боллоо. Бие биенээ гутаах оролдлого хангалттай явсан, одоо болио. Богино хугацаанд нэгдэж, нийлээд ажлаа хийгээд явах юм руу орох ёстой.

## Би Э.Бат-Үүлийг баатар болтол нь дэмжсэн цаашид ч дэмжинэ

С.Зоригийн амийг хөнөөсөн хэрэг гарсанаас хойш хууль хяналтын байгууллагынхан олон жил нойр хоолгүй ажилласан. Тэд хэн нэгэн хүнийг хэлмэгдүүлэх ямар ч зорилго тавиагүй шүү. Ер нь С.Зоригийн хэрэг шүүхийн шат руугаа очиж, шийдэгдэх хэмжээнд очиж байгаа юм болов уу гэсэн ойлголт надад байна. Монгол Улсын Ерөнхий прокурор бол төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх. Тиймээс би Ерөнхий прокуророос асууж, тодруулдаг. Э.Бат-Үүлийн хийсэн мэдэгдлийн тухайд "хэлмэгдүүлэх гэж байна, их эвсэл байгуулаа" гээд олон зүйл бий. Ер нь би Э.Бат-Үүлийг үргэлж дэмжиж ирсэн. Баатар болтол нь дэмжсэн. Цаашдаа ч дэмжинэ. Гэхдээ С.Зоригийн хэрэг дээр ажиллаж байгаа ажлын хэсгийнхэнд хэн нэгнийг хэлмэгдүүлэх ямар ч зорилго байхгүй. Байх ёсгүй гэдгийг Ерөнхий прокурорт үргэлж хэлж байгаа. Улс төрөөс болоод энэ хэрэг илрэхгүй удсан байх гэж би хардаг. Өөрийн бодол өөртөө л зөв гэдэг. Хүн санал, бодлоо илэрхийлэх, бүрэн эрхтэй.

Би Ерөнхийлөгч болсон цагаас миний ширээн дээр, миний анхааралд өдөр тутам байдаг нэг асуудал бол энэ С.Зоригийн хэрэг. Түүний амийг хөнөөсөн алуурчныг монголчууд мэдэх хэрэгтэй гэж боддог. Энэ хууль хяналтын байгууллага болон тэдний ажилд Э.Бат-Үүл талархаж явах хэрэгтэй. Монголчууд талархаж ёстой. Энэ ажил нэлээд ахицтай явж байгаа гэдгийг би хэлэе.

## "Bank of China"–г оруулж ирэх асуудлыг Үндэсний аюулгүй зөвлөл дээр ярина

Банктай холбоотой асуудлыг чөлөөлөх, хоёр дахь зах зээлийг бий болгох. Хувийн аж ахуйн нэгжүүд нэг хүний өмч байхаа больё, Монголын ард түмэнд хувьцаагаа зар, Засгийн газар, УИХ-ын зүгээс ажлаа хий, хуулиа батал. Засгийн газар төсвөө оруулаад ирдэг, УИХ нь дураараа тэлж байдаг, батлсны дараа дандаа тодотгож байдаг. Сахилга бат гэдэг юмыг ОУВС-ай хэлэлцээр хийж байгуулахгүй л юм бол эндээс гарахгүй. Одоо энд, тэндээс мөнгө зээлнэ гээд л байна. Ер нь манайд мөнгө зээлж магадгүй, эдний хүсээд байгаа мөнгийг манай өмнөд хөрш л өгч магадгүй. Миний барьж байгаа байр суурь бол энэ талаар ярьж болно. Харин ганцхан өмнөд хөрштэй биш, БНСУ, хойд хөрш, Европоос Герман байж болно. Тухайлбал, Мексик маш хүнд байдалд орж байгаад, АНУ-тай ярьж байгаад, өөрийн өндөр хүүтэй авсан бондоо АНУ-ын хамгийн бага хүүтэй мөнгөөр солиулан зээл авсан. Тэгээд л эдийн засгаа босгоод ирсэн туршлага байна. Явж, явж байгаад нэг орон дээр тунаж магадгүй. Хөнгөлөлттэй хүүгээр сольж болно. Гэхдээ Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн хүрээнд байж болох зүйл юм.

Манай өмнөд хөршийн Монголын эдийн засагт оролцож байгаа байдал аль ч орноос илүү байгаа. Өмнөд хөрш маань манай хамгийн том худалдан авагч, хамгийн том хөрөнгө оруулагч, хамгийн том банк санхүүгийн салбарт хамтарч ажиллаж байгаа улс. Бид чинь үндэсний аюулгүй байдлын өөрийн гэсэн үзэл баримтлалтай, баримталдаг зарчимтай. Нэг орны хөрөнгө оруулалт ямар төвшинд байх эсэхийг боддог улс. Тэгээд ч Монгол орны байршил маг өвөрмөц. Гэхдээ цаашдаа Монголын ард түмэнд хэрэгтэй зүйлүүд дээр хамтарч ажиллах ёстой. Харин миний байр суурь бол "Bank of China" гэх Хятадын банк Монголд орж ирээд зээл өгөөд, явах шаардлага алга. Аль ч орноос Хятадын санхүүгийн оролцоо Монголд өндөр байна. Харин ч шаардлагатай өөр орны төвшинг хангачихсан банкны салбар байгаа бол болж байна. Манай санхүү рүү орж ирж байгаагүй, хөрөнгө оруулалт хийгээгүй улс орон байвал оруулах хэрэгтэй. Иймэрхүү байдлаар бид тэнцвэрээ барьж явах шаардлагатай. Сая Ц.Нямдорж мэдэгдэл хийж байхдаа ярьж байсан. Бид "Bank of China"-г оруулж ирэхээр ярьж байгаа гэж байсан. Харин энэ банк оруулж ирэх асуудлыг чинь Үндэсний аюулгүй зөвлөл дээр ярина шүү.

## Ерөнхийлөгч ажлаа өгөөд хаачих вэ...

Би яг үнэндээ Монгол Улсын маргааш хийх ажилд л санаа зовж байна. Түүнээс өөрийн ажил, өнгөрсөн үйл явцад миний мөр яаж үлдэх бол гэдэгт огт санаа зовохгүй байгаа. Ажил хийх шаардлагатай бол би зүтгэх л болно. Монголын улс төрд юу хэрэгтэй болон ямар боломжууд Монголыг тойрч алга болоод байгааг би харж байна.

Би яагаад хүмүүсийн ад болоод байдаг вэ гэхээр хуулийг, эрх чөлөөг өмөөрдөг. Эрх ашгийн асуудал гарч ирэхээр би Монголыг өмөөрдөг. Миний барьдаг хэмжүүр шугам нь тэр. Үүнээс болоод өөрөөр бодож байгаа, тэр хүмүүст, тэр бүлэглэлд ад болдог нь үнэн. Би хэзээ ч хаана ч энэ байдлаараа л байх болно. Хэрвээ би Ерөнхийлөгчийн ажлыг өгөөд, Ц.Элбэгдоржийг хуулийнхан шалгах дээрээ тулаад ирэхээр ямар байхыг та нар харж болно. Би нэг ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл дуудахгүй ээ. Хуулийнхан намайг дуудаад "ийм асуудлаар тодруулах зүйл байна" гэхэд нь би зангиагаа зүүгээд, гутлаа өмсөөд очно. Түүнээс би нэг телевиз тавиад өөрийгөө өмөөрүүлээд явах хүн биш. Би сөрөг хүчний удирдагч байхдаа шалгуулаад, цагаадаад гарч л байсан. Би маш олон асуудлаар хуулийн өмнө очдог. Хуулийнхан асуух ч ёстой. Бүр тэр нь улс төрийн зорилготой байх эсэх нь ч хамаагүй. Байгаа хуулийнхаа дагуу л хуулийнхан ажиллах ёстой. Би хуулийг өмөөрдөг, хуулийн шударга ажиллаж байгаа хүмүүсийг өмөөрдөг. Хугацаа гэж сайхан юм байх юм. Би 2017 оны долдугаар сарын 10-нд дараагийн Ерөнхийлөгчид хадгаа өгнө. Би Ерөнхийлөгч болж байхдаа УИХ-аар нэг шийдвэр гаргуулчихсан юм. Тодруулбал, долдугаар сарын 10-нд Ерөнхийлөгчийн ажил солилцдог өдөртэй болох өдрийг бий болгосон. Яг тэр өдрөө би ажлаа өгөөд л энэ ордноос гарна. Хугацаатай юм үнэхээр сайхан юм байна. Тэр цагаас хойш би та бүхний дунд инээмсэглээд амьдарч чадна. Та бүхэн ч мэдэж л байгаа байх. Би ажилтай, албан тушаалтай байхаасаа ажилгүй, албан тушаалгүй байхад миний рейтинг өндөр байдаг. Би энэ ард түмний төлөө хийх ажил надад олон байна. Би өөрийнхөө албан тушаалыг, өөрийнхөө ах дүү, үр хүүхэддээ зориулан ашиглаж байгаагүй. Тиймээс би ийм зүйлийг л бусдаас нэхдэг. Ёстой эцсийн амьсгалаа хураатал Монголын ард түмний төлөө хийх юм байвал зүтгэж байгаад дуусна. Миний ажил Ерөнхийлөгчийн ажлаар буюу ирэх долдугаар сарын 10-аар дуусахгүй гэдгийг хэлчихье.

## Хүн төрөлхтөн 125-аас өндөр наслах боломжгүй

Хүн төрөлхтөн 125-аас илүү наслах боломжгүй байж магадгүй гэж АНУ-ын судлаачид үзэж байна. Анагаах ухааны хөгжил энэ хязгаарыг давахад тусалж чадахгүй байж магадгүй гэж тэд хэллээ. Хүний үхэл болон хүн амын талаархи сүүлийн 100 жилийн хугацаанд цуглуулсан мэдээ мэдээллийг Альберт Эйнштейний нэрэмжит Анагаах ухааны коллежийн эрдэмтэн судлаачид 40 улсаас авч судлан дүн шинжилгээ хийжээ.Улс бүрийн хүн амын дундаж наслалт тасралтгүй нэмэгдсээр ирсэн боловч 1980-аад оноос хойш 100 буюу түүнээс дээш настай хүмүүсийн тоо нэмэгдэх нь зогссон байна. Дөрвөн улс, тэдгээрийн дотор Франц болон Японд дэлхийн дунджаас урт насалж буй хүмүүс хамгийн олон байна.

1970-аад оноос 1990-ээд оны эхэн үе хүртэлх хугацаанд дундаж наслалт жил бүр 0.15 жилээр нэмэгдсээр байжээ. Харин 1997 онд энэ үзэгдэл оргил үедээ хүрээд, буурч эхэлсэн аж. Мөн онд Францын иргэн эмэгтэй Жанна Кальман 122 насандаа хорвоогийн мөнх бусыг үзүүлж байжээ. Түүнийг түүхэн дэх хамгийн урт насалсан хүн гэдгээр нь сайн мэдэх билээ. Хүний насны хязгаар болох 125-аас давах магадлал 10 мянгад нэг хүрэхгүй байгааг статистик харуулж байгаа аж. Энэ нь хүн төрөлхтний дундаж наслалт цаашид нэмэгдсээр байх болно гэсэн таамаглалтай зөрчилдөж байгаа юм.

# АНУ-ЫН ХОЁР ДАХЬ СНӨҮДЭН




Б.ДАВАА

Дэлхий даяар дуулиан шуугиан тарьж, томоохон гүрнүүдийн дунд хүртэл оч үсэргээд амжсан хэргүүдийн нэг бол яах аргагүй АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын агентлагийн ажилтан асан Эдвард Снөүдэний илчлэлт байсан юм. Тэрбээр АНУ, Британий Засгийн газрын маш нууц материалуудыг олон нийтэд задалсанаар энэ хэрэг дэгдсэн байдаг. Уг материалууд дунд АНУ, Европын утасны метадатаг замаас нь хуулах программаас гадна PRISM, XKeyscore, Tempora зэрэг интернэтийн хянах программууд илчлэгдсэн юм. Тэгвэл тус агентлагийн дахин нэг ажилтан баривчлагдсан тухай АНУ-ын Засгийн газар мэдэгдлээ.

Тодруулбал, Үндэсний аюулгүй байдлын агентлагийн гэрээт ажилтан нууцын зэрэглэлтэй мэдээллийг хулгайлсан хэрэгт сэжиглэгдэн Холбооны мөрдөх товчоонд саатуулагдсан тухай мэдээллийг ил болгосон юм. Тус улсын Хууль зүйн яамнаас гаргасан албан ёсны мэдэгдэлд Мэрилэнд мужийн Глен Бурниед оршин суугч 51 настай Харолд Томас Мартин гэгчийг нууц задруулсан хэргээр баривчилсан байна. Түүнийг "Төрийн албан хаагч, гэрээт ажилтны хувиар төрийн өмчийн эд хөрөнгийг хулгайлж, нууцын зэрэгтэй материалыг зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх эсвэл эзэмшиж болохгүй" гэх заалтыг зөрчсөн хэрэгт сэжиглэж байгаа ажээ.

Мөрдөгчид сэжигтний орон сууц болон машинаас нь нууцын өндөр зэрэглэлд багтах мэдээлэл бүхий хард дискний хуулбал, электрон хавтаст материал зэргийг олсон байна. Түүнийг өнгөрөгч наймдугаар сарын 27-ны өдөр баривчилжээ. Харолд Томас Мартин АНУ-ын Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асар их мэдээллийг нийтэд задруулсан Эдвард Снөүдэний нэгэн адил "Booz Allen Hamilton" гэх батлан хамгаалах салбарын зөвлөх компанид харьяалагддаг байсан гэнэ. Баривчлагдах хүртлээ ч тус компанидаа ажилладаг байсан аж.

Нью Йорк таймс сонинд бичсэнээр тус компани Үндэсний аюулгүй байдлын газрын хэрэгжүүлж буй олон нууцын зэрэглэлтэй кибер гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаанд оролцож байжээ. Мөрдөгчид энэ удаагийн баривчилгааны өмнө ОХУ, Хятад, Иран, Хойд Солонгос зэрэг орны хакерууд АНУ-ын мэдээллийг хакердаж байсан "Shadow Brokers" гэх хакерын бүлэглэлийг мөрдөн шалгаж байсан юм. Энэ удаагийн хакеруудын эсрэг үйл ажиллагаа амжилт олбол Үндэсний аюулгүй байдлын агентлаг шинэ программ хангамжийг ашиглаж, дотоод сүлжээ рүү ирэх халдлагад хяналт тавих боломжтой болох гэнэ.

Одоогоор нууц мэдээлэл хулгайлсан эсэх нь эцсийн байдлаар тогтоогдоогүй боловч, Харолд Томас Мартиныг өөр улс орны тагнуул байх магадлал маш бага гэдгийг албаныхан онцолж байна.

## Филиппинчүүд Ерөнхийлөгчдөө "онц" дүн тавилаа

Филиппиний өнгөрсөн зургадугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд өмнө нь Давао хотын захирагчаар ажиллаж байсан "шийтгэгч" хочит Родриго Дютерт сонгогдсон. Түүнийг шийтгэгч гэж нэрлэсэн нь ч учиртай. Тэрбээр хотын даргаар ажиллаж байхдаа гэмт хэрэгтнүүдтэй хатуу тэмцэж байсан тул ийн нэрлэгдэх болсон байдаг. Улмаар сонгуульд олонхийн санал авч, хотын даргаас улсын Ерөнхийлөгч болсон эрхэм өөрийн "шийтгэх" бодлогоо улам өргөжүүлж, цагдаа нарт гэмт хэрэгтний амийг хороох эрхийг өгч, хар тамхины бүлэглэлийн эсрэг тэмцэж эхэлсэн.Түүнийг Ерөнхийлөгч болсноос хойш 3000 орчим хүн цагдаагийн гарт эсвэл цаазлуулж амиа алдсан гэсэн мэдээллийг ч зарим эх сурвалж дамжуулж байгаа юм.Тэгвэл ард иргэд нь хэрхэн үнэлж буйг тандах зорилгоор явуулсан олон нийтийн судалгааны дүнг өчигдөр албаны эх сурвалж танилцууллаа. Ерөнхийдөө Ерөнхийлөгчийн албан тушаалд томилогдоод гурван сарын нүүрийг аль хэдийнэ үзсэн Родриго Дютертын дэмжигчдийн хувь тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа юм. Дээр дурьдсан хар тамхины эсрэг дайныхаа хүрээнд олон хүнийг "цааш нь харуулсан" хэдий ч, иргэд нь эргэлзээгүйгээр түүний үйл хэргийг дэмжиж буй бололтой. Тус улсын нийслэл Манила хотод төвтэй "Social Weather Stations" гэх байгууллага олон нийтийн судалгааг явуулжээ.



Судалгаа өнгөрсөн сарын 24-27-ны өдрүүдэд болж, насанд хүрсэн 1200 гаруй хүнийг санамсаргүй байдлаар сонгон хамруулсан байна.

Тэгвэл судалгаанд оролцогсдын 76 хувь нь Ерөнхийлөгчийнхөө бодлогыг дэмжиж буйгаа илэрхийлсэн бол 11 хувь нь эсэргүүцсэн сонголтыг дугуйлсан байжээ. Харин үлдсэн хувьд нь "Сайн мэдэхгүй байна" гэж хариулсан аж.

## Сольсон "Galaxy Note 7"-оос ч утаа гарч, шатжээ




АНУ-д нэгэн зорчигчийн ухаалаг гар утаснаас утаа гарч, шатсаны улмаас нисэх онгоцноос хүмүүсийг буулгажээ. Уг гар утас нь батарей нь хэт халснаар дэлбэрсэн тохиолдол цөөнгүй гарсны улмаас эргүүлэн татсан утсыг орлуулан "Samsung Electronics" корпорациас өгсөн шинэ гар утас байсан аж. Энэ хэрэг лхагва гарагт Кентукки муж улсын нисэх онгоцны буудалд болжээ. Зорчигч болох нэгэн эрэгтэйн ухаалаг гар утаснаас утаа уугиж эхэлсний дараа зорчигчид болон нисэх багийн гишүүд нийлсэн 75 хүнийг бүгдийг нь онгоцноос буулгасан байна. Аз болоход, энэ явдлын үеэр хүмүүс гэмтэж бэртээгүй байна.

АНУ-ын Иргэний нисэхийн ерөнхий газраас чухам ямар загварын гар утас шатсаныг мэдэгдээгүй боловч тус улсын хэвлэлүүдэд бичиж байгаагаар, өнгөрсөн наймдугаар сард худалдаанд гаргасан "Galaxy Note 7" байжээ. Батарей нь хэт халсны улмаас шатаж дэлбэрсэн тохиолдол цөөнгүй гарсны дараа Өмнөд Солонгосын "Samsung" корпораци уг шинэ бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлээс эргүүлэн татаж, худалдан авсан хүмүүст өөр шинэ гар утас оронд нь авахыг уриалсан билээ. Дээрх хэрэгтэй холбогдуулан "Samsung Electronics" мэдэгдэхдээ "утаа гарч, шатсан гэх төхөөрөмжийг шалгаж үзэх хүртэл ямар нэгэн мэдэгдэл хийх боломжгүй" гэсэн байна.



## ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# Ямашита Мамору:

# МОНГОЛД АКТУАР ТООЦООЛОЛ ХИЙХ МЭРГЭЖИЛТЭН ШААРДЛАГАТАЙ БАЙНА

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тодруулбал, социализмын үед малчин, ажилчин гэдгээс үл хамааран бүх хүмүүс нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагддаг байсан гэдэг. Харин нийгмийн өөрчлөлтийг дагаад нийгмийн даатгалын системд ч өөрчлөлт орсон. Монгол Улс социализмаас зах зээлийн эдийн засагт шилжиж орсон тэр үеэс албан журмаар хамрагддаг Нийгмийн даатгалын тогтолцоо өөрчлөгдөж, сайн дураар даатгуулах даатгалын хэлбэр бий болсон. Гэтэл өтөл нас хүртлээ нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй малчид яаж тэтгэвэр авах вэ. Мэдээж энэ асуудал Монголын Засгийн газрын санаа зовоосон асуудлын нэг байсан болов уу гэж бодож байна. Ер нь тухайн орны өөрийн хэв маягаас хамаарч нийгмийн даатгалын систем харилцан адилгүй хэрэгждэг. Европын ихэнх орнуудад үйлдвэрлэл, аж ахуй хөгжсөн байдаг тул байгууллагын ажилтны хувиар ихэнх иргэд нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. Гэтэл Японд ямар нэг байгууллагад ажилладаг эсэхээс үл хамааран, 20-60 насны бүх хүн шимтгэл төлдөг гэдгээрээ онцлог юм. Японы даатгалын тогтолцооны ач холбогдлыгсурталчлантаниулах нь төслийн нэг зорилго юм. Японы даатгалын тогтолцоонд өнөөдрийг хүртэлх хугацаанд алдаа оноо, амжилт аль аль нь байсан. Төсөл хэрэгжсэнээр Японы Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын газрын холбогдох мэргэжилтнүүд Монголд ирж ажиллахаар болсон. Даатгуулагч иргэн нийгмийн даатгалын шимтгэлдээ хэдийг, хэрхэн төлөх, ямар хэмжээний тэтгэвэр тооцуулж авах вэ гэх мэт тооцоолол хийх өдөр тутмын үйлчилгээг сайжруулах, ажилтнуудыг чадавхижуулах шаардлага байгааг уламжилсан юм. Тиймээс яг энэ үйл ажиллагааг хариуцан ажилладаг мэргэжлийн хүмүүс Монголд ирж ажиллаж байна.

**-Төсөл хэдий хэрийн хугацаанд үргэлжлэх вэ?**

-Төсөл энэ оны тавдугаар сард эхэлсэн. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжинэ.

**-Одоогоор төсөл аль үе шатандаа явж байна вэ?**

-Төслийн хүрээнд таван чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Нэгдүгээрт, нийгмийн даатгалын хэлтсүүдийн үйлчлүүлэгчдийг угтан авах үйлчилгээг сайжруулна. Хоёрдугаарт,

...Тэтгэврийг ихэнх хүмүүс өндөр насанд хүрэхээрээ улсаас авдаг тэтгэмж гэж ойлгодог. Гэтэл энэ нь зөвхөн өндөр насны биш, өвчин эмгэг, осол гэмтэл, нас баралтын улмаас эдийн засгийн, амьдралын хүнд байдалд орохоос сэргийлэх нийгмийн хамгаалал байдаг. Тэтгэврийн тогтолцоо өндөр настнуудын орлогын баталгаа болох хэдий ч, залуу үеийнхэнд ч хамааралтай...



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

нийгмийн даатгалын системийн туршлагаас Монголын хөрсөнд буулгаж болох ижил төстэй талыг нь ашиглах, үйл ажиллагааг сайжруулах хүсэлтийг Монголын Засгийн газар Японы Засгийн газарт тавьсны дагуу төсөл хэрэгжих эхлэл нь тавигдсан хэрэг.

**-Тодруулбал?**

-Монголд 65-аас дээш насныхан буюу хүн амд эзлэх өндөр настнуудын хувь өнөөдрийг хүртэл таван хувиас дотогш байсан. Гэтэл насжилтыг урт хугацаанд авч үзвэл, 2100 он гэхэд Монголын хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь 65-аас дээш насныхан болох хандлага ажиглагдаж байгаа. Европын орнуудын хувьд өндөр насжилтын хэмжээ аажимдаа нэмэгддэг байхад Азийн орнуудад насжилт хурдацтайгаар нэмэгдэж байна. Жишээлбэл, Япон байна. 60 жилийн өмнө тус улсын хүн амын 43 хувийг залуус эзэлж, залуусын орон гэгддэг байлаа. Харин одоо тэтгэврийн насныхны хүн амд эзлэх хувь огцом нэмэгдсэн. Монголд ч гэсэн өндөр насжилт нэмэгдэнэ. Тиймээс үүнтэй холбогдуулан Япон улсын өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн Нийгмийн тухайн үйлчлүүлэгчийг хүлээлгэхгүйгээр асуудлыг нь хурдан шуурхай шийдвэрлэх, нөгөө талаас ажилчдаа эрхэлсэн ажлаа цагт нь багтааж үр дүнтэй хийж гүйцэтгэх чадавхийг нь сайжруулна. Мөн байгууллагын нийт ажилчид болон шинэ ажилтанд зориулсан сургалтын агуулга, хэлбэрийг системтэйгээр сайжруулах ажил хийгдэнэ. Дөрөв дэх чиглэл нь актуар тооцоолол хийх мэргэжилтнүүдийг бэлтгэн, чадварыг нь сайжруулах явдал юм. Эцэст нь олон нийтэд таниулах сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Монголд хөдөлмөр эрхэлж буй хүн бүр нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. Гэхдээ төлсөн мөнгө нь хаана байршиж, юунд зарцуулагддаг талаар төдийлөн сайн ойлголтгүй байдаг нь анзаарагдсан. Тиймээс төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НДЕГ-ын ажилтнуудыг Японд сургалтад хамруулж, энэхүү салбарын үйл ажиллагаа хэрхэн явагддагийг бодит байдал дээр нь үндэслэн таниулж, сургана. Нөгөө талаар, Японы мэргэжилтнүүдийг Монголд урьж, сургалт зохион байгуулахаартөлөвлөсөн.Гэхдээ нэг зүйлийг сайн ойлгоосой гэж хүсч байна. Японы баримталдаг нийгмийн даатгалын тогтолцоог Монголд шууд хэрэгжүүлнэ гэсэн үг биш. Салбарын мэргэжилтнүүд өөрийн орныхоо онцлогт тохируулж, хэрэгжүүлж болохуйц туршлагыг нь өөрийн улсын бодлоготойгоо уялдуулах юм. Түүнчлэн, бид зөвхөн зааж сургах гэж ирээгүй. Танай улсын нийгмийн даатгалын тогтолцооноос ч сурах зүйл их бий. Харилцан суралцаж хамтран ажиллана гэж ойлгож болно.

**-Мэргэжлийн зарим хэллэгийг жирийн уншигчид ойлгохгүй. Та актуар тооцооллын талаар энгийн үгээр тайлбарлаж өгөөч?**

-Хүн 50 жилийн дараа хэдэн настай байх вэ гэдгээ хялбар тооцож чадна. Түүнчлэн, 50 жилийн дараа тэтгэврийн насныханхэдбайхыгчэнгийнээр тооцож болно. Харин тэр үед тэтгэвэрολголтодзориулжхэдий хэрийн хуримтлал бүрдүүлэхийг актуар тооцоо гэдэг. Тэтгэвэр гэдэг тэтгэврийн насанд очиход л шийдэгддэг асуудал биш. 50 жилийн дараа тэтгэвэр олголтод шаардагдах хөрөнгийг одоо хэрхэн цуглуулах вэ гэдгийг төсөөлөн, тооцооллыг боловсруулах шаардлагатай. Тиймээс нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэхийн тулд актуарчдыг зайлшгүй бэлтгэх ёстой.

**-Актуар тооцоолол хийх чадвартай мэргэжилтнүүд манайд хэчнээн байдаг юм бол. Төслийн хүрээнд хэчнээн тооны мэргэжилтнийг сургана гэж тооцоолсон бэ?**

-Монголд актуарчид хэд байдгийг тодорхой хэлж мэдэхгүй юм. Гэхдээ цөөхөн байдаг гэж дуулсан юм байна. Тэтгэвэр гэдэг урт хугацаанд авч үздэг нарийн тооцоолол бүхий тогтолцоо. Жил бүр шимтгэлийн хэмжээ ихэсч, багасах тохиолдол гарна. Тиймээс л актуар тооцооллыг өндөр түвшинд хийх чадвартай мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай байдаг юм.

**-Төсөлхэрэгжүүлжэхлэхийн өмнө Монголын Нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар судалгаа хийж үзсэн үү. Иргэд энэ талаар хэр үнэн бодит мэдээлэлтэй байдаг бол?**

-Манай төсөл дээр 6-7 хүн ажиллаж байгаа. Нийт иргэд салбарын үйл ажиллагааны талаар ямар ойлголттой байдаг талаарбидодоогоорУлаанбаатар хотын зургаан дүүрэгт сэтгэл ханамжийн судалгаа явуулж байна. Тэтгэврийг ихэнх хүмүүс өндөр насанд хүрэхээрээ улсаас авдаг тэтгэмж гэж ойлгодог. Гэтэл энэ нь зөвхөн өндөр насны биш, өвчин эмгэг, осол гэмтэл, нас баралтын улмаас эдийн засгийн, амьдралын хүнд байдалд орохоос сэргийлэх нийгмийн хамгаалал байдаг. Тэтгэврийн тогтолцоо өндөр настнуудын орлогын баталгаа болох хэдий ч, залуу үеийнхэнд ч хамааралтай. Тухайлбал, 100 сая төгрөгийг хэр хугацаанд цуглуулах вэ. Сар бүр 10 мянган төгрөгхуримтлуулнагэвэл10000 сар буюу 830 жил шаардагдана. Тэгвэл 10 мянган хүн тус бүр 10 мянган төгрөг цуглуулбал, 100 саяын хуримтлал шууд л бүрдэнэ. Улмаар хуримтлал үүсгэсэн хүмүүсийн хэнд ч амьдралын хугацаанд нь гэнэтийн өвчин зовлон тохиохыг үгүйсгэх аргагүй. Малчид морь, тэмээнээс унаж гэмтэх, авто осолд орж болно шүү дээ. Энэ бүх эрсдэлд энэхүү хуримтлалаас зарцуулна гэж бодох хэрэгтэй. Гэхдээ хуримтлал бий болгох нь улсын бодлогын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа байх учиртай. Үүнийг хэн нэгэн компани, хувь хүн үүсгэх боломжгүй. Иймд нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа, тэрхүү үйлчилгээг авч буй бүх хүн зөв ойлголттой байвал улсын хэмжээнд том хуримтлал болж чадах юм.

**-Японд хэдэн наснаас тэтгэвэр авч эхэлдэг вэ. Энэ талаар сонирхуулахгүй юу?**

-Японд 65-аас дээш насны иргэн тэтгэвэр авч эхэлдэг. Эрэгтэй, эмэгтэй хамаарахгүй. Олон жилийн өмнө 55 нас хүрсэн иргэн тэтгэвэр авдаг байсан. Харин эдүгээ насжилт нэмэгдсэн, 55 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн чадвараа хадгалсан хэвээр байгаатай холбогдуулан тэтгэврийн насыг 65 болгон өөрчилсөн юм.

**-Засгийн газраас өндөр настнуудын тэтгэврийг жил бүр нэмэх асуудлыг хэлэлцдэг. Харин танай улсын нийгмийн даатгалын тогтолцоонд энэ мэт арга хэмжээ байдаг уу?**

-Аливаа улсад иргэд нь нийгмийн даатгалын шимтгэлээ бага төлж, их тэтгэвэр авахыг хүсдэг. Японы хувьд тэтгэврийн насанд хүрэхэд өндөр тэтгэмж авахын тулд, сард хэдий хэмжээний шимтгэл төлөх ёстой гэдгийг анхнаас нь тооцсон байдаг. Шимтгэлээ хэр хэмжээнд төлнө, тэр нь насан туршдаа авах тэтгэмж болно. Мэдээж боломжийн хэмжээний тэтгэвэр тогтоолгочихвол амьдралынх нь баталгаа болдог учир өндөр настнуудын хувьд тэтгэвэр нэмэгдэхэд таатай хандалгүй яах вэ. Гэхдээ тэр хүний тэтгэврийг олгохын тулд залуу үе, хөдөлмөрчид нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг өсгөх шаардлагатай болно. Гэвч энэ нь эсрэгээрээ шимтгэл төлөгч иргэдэд хүнд ачаа болох нь бий. Жишээлбэл, би нэг компанид ажилладаг гэж бодъё. Гэтэл нийгмийн даатгалын шимтгэлийг бусдаасаа хэт өндөр ногдуулаад байвал тэнд ажиллах нь хүндрэлтэй санагдаж мэднэ. Иймээс л мэргэжлийн актуарчид хэрэгтэй. Ирээдүйд хүн бүр тэтгэвэрт гарах нь тодорхой. Харин тэр үед хэр хэмжээний хуримтлал хэрэгтэй болох, хэдий хэрийн мөнгийг тэтгэвэрт зориулж, хэчнээн жилийн өмнөөс хэр хэмжээний шимтгэлээр хуримтлуулах вэ гэх мэт орлого зарлагын тэнцвэрийг сайтар тооцож гаргах шаардлагатай. Актуар зөвхөн өнөөдөр, маргаашийн асуудлыг биш, урт хугацааны тооцооллыг гаргадаг учир маш их ач холбогдолтой.

**-“Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл” Азийн орнууддундаа зөвхөн Монголд хэрэгжиж байна уу. Өмнө нь өөр улсад хэрэгжүүлсэн туршлага бий юу?**

-Азийн улс орноос төслийг хэрэгжүүлж буй анхны улс нь Монгол. Дээр нь ЖАЙКА олон улсын байгууллагын санхүүжилттэйгээр нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжиж буй анхны төсөл байгаа юм.

**-Төсөл дөрвөн жил үргэлжилнэ гэсэн. Дөрвөн жилийн дараах үр дүнгийн талаар та ямар төсөөлөлтэй байгаа вэ?**

-Төсөл хэрэгжихээс өмнөх нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн тоо хэд байсан, хэрэгжсэний дараа хэд болсон бэ гэдгээр төслийн үр дүн тодорхойлогдох болов уу. Гэхдээ зөвхөн шимтгэл төлөгчийн тоог нэмэгдүүлэхийн тулд л төсөл хэрэгжүүлж байна гэж ойлгох нь өрөөсгөл юм. Бид өнөөдөр 10 байсан тоог 20 болгоход анхаарлаатөвлөрүүлэхгүй.Хэрэв ингэж хандвал Монгол улсын нийгмийн даатгалын тогтолцоог хэрхэн зөв удирдах, Монгол Улсын өнөөгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан цаашдаа яаж тасралтгүй зөв, оновчтой хэрэгжүүлэх вэ гэдэг асуудалтай уялдахгүй байх. Мөн нийгмийн даатгалын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг мэргэжилтнүүдийн ур чадвар хэрхэн дээшилснээр төслийн үр дүнг хэмжиж болно.



## АЯНЫ БОГЦ

# ХӨГЖИЛ ГЭДЭГ ЧИНЬ ХАЯАНД БАЙНА ДАА



### Нэг. Оршил болгохуй

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа холбоо нийгмийн бүхий л салбарт хөгжин гүнзгийрч буйн нэг илрэл нь хоёр орны сэтгүүлчдийн байгууллагын хамтын ажиллагаа юм. Оймогхоны өдрүүдэд Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийн хамтарсан "Нэг бүс нэг зам" аяны хүрээнд Хятад Улсын боомтуудтай танилцах долоо хоногийн аянд МСНЭ-ийг төлөөлж МҮОНРТ, "МОНЦАМЭ" агентлаг, "Стар" телевиз, өдөр тутмын "Үндэсний мэдээ" сонин, Зэвсэгт хүчний "Соёмбо" сонин, Эрдэнэтийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагчид нэгдсэн юм. Хятадын талаас "Синьхуа" агентлагийн Өвөр Монгол дахь салбар, "Ардын өдрийн сонин", "Эдийн засгийн өдрийн сонин", "Хятадын өдрийн сонин", Буян төвийн "Ардын радио", "Хятадын мэдээ" агентлаг, "Солонго" мэдээллийн төв, Өвөр Монголын радио, телевизийн мөн 10 гаруй сэтгүүлч, сурвалжлагч нар оролцсон. Монголын сэтгүүлчдийн аян замын ая тухтай байдлыг хангахад Улаанбаатар төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээнийхэн сэтгэл гаргаж, хоёр улсын хилийн боомтыг цаг хугацааны алдагдалгүй саадгүй нэвтрүүлэхэд Замын-Үүдийн Засаг даргын Тамгын газар, Замын-Үүдийн Гааль, Хилийн цэргийн шалган нэвтрүүлгийнхэн шуурхай ажилласныг тэмдэглэх ёстой.

Эрээн хотын шалган нэвтрүүлэх боомтод биднийг ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны Гадаад харилцааны газрын дарга Д.Баянжаргалаар ахлуулсан хариуцлагатай албан тушаалын хүмүүс гүн хүндэтгэлтэйгээр угтаж, өндөр зэрэглэлийн зочид буудалд байрлуулсан зэрэг нь аль ч газрын сэтгүүлчдийн нэр хүнд өндөр байдагтай холбоотой гэдгийг дурдахад илүүдэхгүй биз ээ. БНХАУ-ын удирдлагын зүгээс улс орныхоо хөгжил дэвшлийн ололт амжилт, боомтуудынхаа үйл ажиллагааг ямар ч нууцлалгүй чөлөөтэй сурвалжлуулахыг эрхэм зорилгоо болгосон нь Эрээн хотын Шалган нэвтрүүлэх боомтоос л эхний шан нь тавигдсан гэж хэлж болно. Тэнд өндөр үнэ өртгийг үл харгалзан Хяналтын рентген төхөөрөмж байрлуулсан нь өчүүхэн жижиг микро зүйлийг ч аваад гарах ямар ч боломжгүй зэрэг техник технологийн үсрэнгүй дэвшлээ "Гайхуулж байна уу?" гэлтэй санагдаж байлаа.

### Хоёр. Боомтуудаар аялсан таван өдөр

Монголын сэтгүүлчид ӨМӨЗО-ны Эрээн хотын Гаалийн буудалд тухалж хоноод, Холбоолон шалгах байрны байдалтай анхлан танилцсанаар Эрээн хотын боомт болон Төмөр замын боомтын үйл ажиллагаа, чөлөөт худалдааны бүс, хил дамнасан хамтын ажиллагааны бүсийн байдалтай танилцсан зэрэг бүтэн өдрийн ажил Эрээн хотод үргэлжилсэн. Миний бие тэртээ ерээд оны эхэн үед Шилийн гол аймагт зорчоод "Ил цагаахан яриатай Жан дарга" аян замын тэмдэглэл, мөн оны сүүлч үест "Эрээний эрээн бараан" сурвалжлагыг "Улаанбаатар" сонинд тус тус нийтлүүлж байснаас хойш энэ зүгт хөл тавилгүй 18 жилийг улираажээ. Гэтэл тэр үеийн Эрээн, өнөөдрийн Эрээн хоёрыг харьцуулбал ёстой л өдөр шөнө шиг ялгаатай болжээ. Хот төлөвлөлт, цэвэр цэмгэр орчин, гудамж замын цэлгэр чөлөөтэй байдал зэрэг нь хэнд ч уужуу тайван амьдрал бэлэглэж байсныг тэмдэглэхгүй өнгөрч боломгүй санагдана.

Эрээн боомтын орлогч дарга Сайн-Өлзийн ярьснаар тус улс 13 дугаар таван жилийн төлөвлөгөөгөө эрчимтэй хэрэгжүүлж байгаа юм байна. Төлөвлөгөөнд тусгаснаар Эрээн боомтыг Олон улсын өндөр зэрэглэлийн боомтын хэмжээнд хүргэж, хилээр гарч байгаа бараа таваарт аль болох шуурхай

> ..."Нэг бүс нэг зам" боомтоор аялах аяны сүүлчийн өдрүүд Ордос хот, Чингисийн онгонтой танилцах байлаа. Тус улсын баруун өмнөд хязгаарт хөгжин дэвжиж буй Ордос хотын сайхан бүхнийг хэлж барахын аргагүй. Нарны гэрлийг чөлөөтэй тусгахаар зохиомжилсон аварга том онгоцны буудлаа өөр хаана ч байхгүй гэж нисэх буудлын эрхлэгч Гу Мин бахархан ярьж байв. Ер нь уулзсан хүн бүрийн амнаас улс орноороо, хөгжил дэвшлээрээ бахархсан өнгө аяс ямагт цухалзаж байсан нь ирээдүйдээ итгэлтэй буйн зэрэгцээ амьдрал ахуй нь өөдрөг буйн илрэл гэж хэлж болох...

үйлчилгээ нэвтрүүлэх зорилго тавьж, энэ нь аль хэдийнэ хэрэгжиж эхэлжээ. Энэ боомтоор өдөрт 5000, жилд хоёр сая гаруй зорчигч нэвтэрдэгийн дийлэнх хувийг монголчууд эзэлдэг аж. Ийнхүү хяналт шалгалтын нөхцөл байдлыг сайжруулж, 12 гарцтай болгосноор жилд 10 сая зорчигч нэвтрүүлэх боломж бүрджээ. Эрээн хотод чөлөөт худалдааны бүс, агаарын боомт буюу онгоцны буудал баригдсанаар ажлын байр олноор нэмэгдэж, багаар ажиллахад илүүтэй анхаарах болсныг уулзсан хүн бүр онцолж байв. Рентген шалгах төхөөрөмжөөр илрүүлсэн, манай сайн эрчүүлийн авч гарах гээд бүдэрсэн баавгайн савар, хөлдөөсөн чоно, цагаан будаа зэрэг есөн шидийн зүйлийг эд мөрийн баримт болгон үзүүлж байлаа.

Дараа нь Төмөр замын үйл ажиллагаатай танилцаад, тэднийхний ярьдгаар Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүсэд очсон. Чухамдаа чөлөөт худалдааны бүс болсон тэр нүсэр байгууламжийг 2014 онд ашиглалтад оруулжээ. Нэлээд хэд хоногийн өмнө Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд манай улсын цөөнгүй аж ахуйн нэгж, байгууллага оролцоод нутаг буцжээ. Харин Ч.Гансүх захиралтай "Амин шигтгээ" аж ахуйн нэгжид 10 хоног үнэ төлбөргүй ажиллах эрх олгосонтой тохиолоо. Тус аж ахуйн нэгжийн менежер Ч.Төмөрчөдөртэй уулзахад "8000 юаниас доош үнэтэй бараанд татвар авахгүй байгаа. Ер нь есөн төрлийн 100 гаруй бараа оруулж ирэхийг зөвшөөрдөг. Бидний хөдөлмөрийг Худалдаа аж үйлдвэрийн танхим дэмжиж, өвөрлөгч нөхөд маань тодорхой хөнгөлөлт үзүүлж байгаад баяртай байна" гэж ярьсан. Мөн өдөр Эрээн хотын дарга, хоёр орны сэтгүүлчдэд мэдээлэл хийж, тэдний сонирхсон асуултад дэлгэрэнгүй хариулт өгсөн. Хятадын 10 гаруй боомтоос эхний гуравт ордог Эрээн боомт нь тус хоёр улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг учраас Хятадын Засгийн газраас ихээхэн анхаарч, чамгүй хөрөнгө, мөнгө хаядаг нь алхам тутамд мэдрэгдэж байлаа. Эрээн хотын удирдлагын зүгээс хил дамнасан хамтарсан чөлөөт бүс байгуулах төсөл боловсруулсан ч хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хийгдээгүй учраас зогсонги байдалтай байгааг цааш холбогдох хүмүүст уламжилж өгөхийг тэрбээр хүсэмжилж байсан. Манай нэг сэтгүүлчийн Замын бөглөрөлгүй ийм сайхан орчинг хэрхэн бүрдүүлж байгааг асуусан асуултад "Би Улаанбаатар хотын захирагчтай уулзах уулзалтаас 20 минут хоцорч очсоныг Э.Бат-Үүл дарга энэ бол таны буруу биш, бидний буруу гэж хүлцэл өчиж байсныг тод санаж байна. Манайх Улаанбаатартай адилтгах аргагүй жижиг хот л доо. Гэхдээ 40,000 гаруй автомашинтай. Зам өргөн, ямар машин хаагуур явахыг нь нарийн чанд тогтоогоод өгчихсөн болохоор түгжрэл гэсэн ойлголт байхгүй ээ. Ямар ч байсан соёл иргэншлийг үлгэрлэн харуулсан орчин үеийн хот болгохын төлөө бид чармайн ажиллаж байна. Замын хөдөлгөөний хууль дүрмийг маш хатуу сахиулдаг болохоор иргэдээс зөрчил гаргах нь тун ховор. Дээр нь хамгийн сүүлийн үеийн цахим хэрэгслийг зам дагуу олноор нь суурилуулсан нь ч үр дүнгээ өгч байгаа" гэсэн илэн далангүй хөөрөлдөөн бүтэн нэг цаг гаруйн хугацаанд үргэлжилсэн юм.

Маргааш нь ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотыг зорьж, таван цаг гаруй довтолгоод Далан хар уулын өвөрт төвхнөсөн буурал хотод хөл тавьсан. Үдээс хойш олон улсын "Цагаан суварга" нисэх онгоцны буудлын үйл ажиллагаатай танилцуулсан. Дэвж байгаа бүргэдийн хэлбэр бүхий эл буудлын тохилог хийгээд тоног төхөөрөмжийн цахимжилтыг нуршихын хэрэггүй биз ээ. "Бүх зүйлийг лазераар



шалгадаг болохоор зөрчил гарах тохиол бараг байхгүй" гэж нисэх буудлын ажилтан Лю Жи Лан итгэлтэй нь аргагүй ярьж байсан. Хөх хотоос Халиут суурин 500 гаруй мод газар. Зам гэж зам болохоор зогсож сааталгүй довтолгоно. Хүний олноор уулыг ч болов нураах их хүч энэ оронд байгаа ч хууль дүрмээ ягштал дагаж биелүүлнэ гэдэг үсрэнгүй хөгжлийн нэг гарц юм байна даа гэсэн бодол төрж явлаа. Үдшийн бүрий орчлонг нөмөрсөн цаг дор тус суурины мөн л тохилог сайхан буудалд тухлаад маргааш нь "Ганц мод" боомтыг зорьсон. Баяннуур аймгийн Урадын дунд хошууны төв Халиут сууринтаас 130 гаруй мод газарт төвхнөсөн тус боомттой хил залгаа манай улсын "Гашуун сухайт" боомтын хаяг нь тодоос тод харагдаж байх. Монгол орны маань баялаг болсон газрын гүний хар алтыг тэнгийнхээ хэрээр ачсан аварга том могой лугаа мурилзах автомашинууд араасаа дугаарлан зогсох. Нүүрсний тортгонд нүүр нь харласан жолооч нарын царайд хурдхан шиг хил нэвтрэх юмсан гэсэн горьдлогот харц хэнд ч илт мэдрэгдэх. "Гашуун сухайт"-аас цааш багцаагаар лавтайяа 20 гаруй мод газар дугаарлан зогсох уртын урт цуваа бараантан харагдах ийм дүр зураг ердийн үзэгдэл болоод багагүй хугацаа өнгөрчээ. Яахав дээ, ажлын байр олдохгүй 3600 хүний амьдрал ахуйг бага ч атугай дээшлүүлж байгаа гэж эерэгээр бодож болох ч хайран сайхан хар алтаа дэндүү хямд үнээр хил давуулан шидэж байгаад харамсах хүн олон байгааг дурдахгүй өнгөрч боломгүй. Нүүрс тээвэрлэлтийн байдалтай танилцсан хоёр орны сэтгүүлчид Баяннуур аймгийн Урадын дунд хошууны эмнэлэг, "Ганц мод" боомтын сургуультай танилцах боломж олдсон. Тус хошууны эмнэлэг Монгол хүмүүст хөнгөлөлттэй үнээр үйлчилдэгийн зэрэгцээ Өмнөговь аймагт очиж өвчтөнүүдэд оношилгоо хийсэн тохиол ч байгаа аж. 15 эмч, таван сувилагчтай эмнэлгийн 30 ортой байр бүрэн ашиглалтад орвол Монгол хүмүүс ч хэвтэж эмчлүүлэх боломжтой болох юм байна. Харин 2012 оны есдүгээр сард байгуулагдсан цэцэрлэг болон бага сургуульд нь 50 орчим монгол хүүхэд суралцаж байна. Дийлэнхдээ нүүрс тээврийн жолооч нарын хүүхэд суралцдаг энэ сургууль тэднээс төлбөр авдаггүйн зэрэгцээ үнэ төлбөргүй байраар хангадаг зэрэг хоёр орны ард түмний нөхөрлөлийг бататгасан цөөнгүй шийдвэр гаргажээ. Харин сонирхолтой нь нэг ангид бүхий



л ангийн хүүхдүүд суралцаж байгаа нь "Дамбийжаагийн цоохор цэргүүд" лугаа санагдсан шүү. Гэхдээ тэднийг тус бүрд нь сургахын төлөө чөмгөө дундартал зүтгэж байгаа Ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Цэцгээ багшийн хөдөлмөрийг үнэлэхгүй байхын аргагүй. Бага ангийн багшаар 36 жил ажилласан энэ багшийн сарын цалин нь 2000 юань гэсэн. Суралцагч хүүхдүүдийн нэг давуу тал нь хятад хэлийг чамгүй сурдаг аж. Хэрвээ хятад хэлнийхээ шалгалтыг боломжийн хэмжээнд өгвөл цааш Хөх хот, Эрээн зэрэг бусад томоохон хотуудад үргэлжлүүлэн суралцах боломж олддог аж.

Хоёр орны сэтгүүлчдийн "Нэг бүс нэг зам" боомтоор аялах аяны сүүлчийн өдрүүд Ордос хот, Чингисийн онгонтой танилцах байлаа. Тус улсын баруун өмнөд хязгаарт хөгжин дэвжиж буй Ордос хотын сайхан бүхнийг хэлж барахын аргагүй. Нарны гэрлийг чөлөөтэй тусгахаар зохиомжилсон аварга том онгоцны буудлаа өөр хаана ч байхгүй гэж нисэх буудлын эрхлэгч Гу Мин бахархан ярьж байв. Ер нь уулзсан хүн бүрийн амнаас улс орноороо, хөгжил дэвшлээрээ бахархсан өнгө аяс ямагт цухалзаж байсан нь ирээдүйдээ итгэлтэй буйн зэрэгцээ амьдрал ахуй нь өөдрөг буйн илрэл гэж хэлж болох. Ордос хотоос 70 мод газарт Чингисийн онгон сүр бараагаа илтгэн ихэмсэгээр оршин байх авай. Байгалийн сайхан цогцолсон эл газарт их эзэн Чингис хаан ташуураа унагаснаар ийнхүү онголон шүтэх их цогцолбор болсон бөгөөд соёлын хувьсгалын жилүүдэд бүрэн бүтнээр нь авч үлдэхийн тулд адармаатай замыг туулсан гашуун үнэн ч бий аж. Онгон тахилгын хэсэг, хааны цогцолбор гэсэн хоёр хэсгээс бүрдэх их хааны маань онгон шүтээн олон хүний нүдийг хужирлаж, сэтгэлийг татах зүйл ихтэй болохыг цухас дурдъюу.

### Гурав. Төгсгөл болгохуй

БНХАУ-ын удирдлагын зүгээс хөрш орнуудтайгаа найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэхэд илүүтэй анхаарч, нэг цонхны бодлогыг эрчимтэй явуулж байгаа нь Монгол, Хятад хоёр орны сэтгүүлчдийн хамтарсан "Нэг бүс нэг зам" аяллаас тод харагдаж байна. Бүтэн долоо хоног хамтран аялж, харилцан туршлагаа солилцсон зэрэг нь сэтгүүлчдийн байгууллагуудын хамтын ажиллагааг улам бататгасан үр дүнтэй ажил байсныг хэлэх нь зүйн хэрэг. Үлэг гүрвэлийн орон Эрээн хотоос эхэлсэн аян маань 2500 гаруй километр замыг туулснаар өндөрлөсөн бөгөөд энэ аяныг үр дүнтэй болгоход тус хоёр улсын сэтгүүлчдийн идэвхтэй хамтын ажиллагаа, аяллыг хөгжөөнтэй болгоход МСНЭ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, Цахим мэдээллийн мэргэжлийн төвийн дарга Ж.Жаргалсайхан, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны Гадаад харилцааны газрын дарга Д.Баянжаргал, мөн газрын Гадаад суртал ухуулгын газрын ажилтан Ван Мин, Хөх хотын Боомтын газрын ажилтан Аянга нарын хүчин чармайлтыг тэмдэглэх ёстой. Хятад улс нарны эрчим хүчийг бүрэн дүүрэн ашиглаж байгааг Тамчийн талаар дүүрэн эргэлдэх салхин сэнсээр жишээлж болно. Бид дэлхийн хөгжлөөс суралцана гэж Эрээн, Хөх хот дээгүүр нисэн тив алгасах биш, ерөөсөө хаянд байгаа Эрээн хотынхоо хөгжлөөс л суралцахад хангалттай юм байна даа гэсэн бодол төрснөө дурдаад энэхүү тэмдэглэлдээ цэг тавиму!

МСНЭ-ийн шагналт сэтгүүлч
Гомбын БААТАРНУМ

MMINFO.

# СПОРТ



Д.СУМЪЯА, М.УРАНЦЭЦЭГ НАР ДЭЛХИЙН ЧАНСААГ ТЭРГҮҮЛЖ БАЙНА

Т.САНЧИР "SBL ХАСЫН ХҮЛГҮҮД" БАГТ ДАХИН ТОГЛОНО

VIII нүүрт

## "Реал", "Барса"-гаас Ракитичийг авахыг оролдсон уу

Испанийн алдарт "Реал Мадрид" клуб өнгөрсөн зуны солилцоо наймааны цонхоор zanалт өрсөлдөгч "Барселона"-гаас хоёр тоглогчийг урвуулах гэж оролдсон билээ. Тэгвэл El Mundo Deportivo-гийн мэдээлж байгаагаар "Реал" Каталаны багаас довтлогч Неймар болон хагас хамгаалагч Иван Ракитич нарыг тун их сонирхсон юм байна. Энэ үйл явдлын дараа "Барселона" Неймартай 2021 он хүртэл гэрээгээ сунгаж, цалинг нь нэмсэн. Харин Иван Ракитичийг зарахаас татгалзжээ. "Реал" болон "Атлетико" гэсэн Мадрид хотын багууд хоёр жилийн өмнө Хорват эрийг "Севилья"-д тоглож байхад нь бас авахыг оролдож байж. Ракитич одоогоор Испанийн Ла лигт таван тоглолтод оролцож, хоёр гоол оруулчихаад байна.

## "Челси" Бонуччиг дэлхийн хамгийн өндөр үнэтэй хамгаалагч болгоно

Английн "Челси" клуб өвлийн солилцоо наймааны цонхоор Италийн аварга "Ювентус"-ын хамгаалагч Леонардо Бонуччиг худалдаж авахаар санаархаж байгаа ажээ. Багийнхаа дасгалжуулагчид шаардлагатай бүх хөрөнгө мөнгийг нь Роман Абрамович гаргахад бэлэн, нэг тоглогчийн төлөө 60 саяыг зарцуулах зөвшөөрөл өгсөн талаар Итали мэргэжилтэн Антонио Конте мэдэгджээ. Хэрвээ "Челси" Бонуччигийн төлөө 60 сая евро зарцуулбал тэрбээр түүхэн дэх хамгийн үнэтэй хамгаалагч болох юм. Өмнө нь "Челси"-гээс 50 сая еврогоор "ПСЖ" руу явсан Бразил эр Давид Луйз хамгийн өндөр үнэтэй хамгаалагч болоод байсан юм. Тэрбээр өнгөрсөн зуны солилцооны цонхоор 30 саяар эргэж ирсэн билээ. Гэвч "Челси"-д тийм ч сайн биш байгаа. Мөн бусад хамгаалагчид ч гэсэн алдаа гаргаж, муу тоглож буй юм. Тиймээс "Челси" хамгаалагчдын төлөө мөнгө цацахаар шийдсэн бололтой.



# ӨЗИЛ, САНЧЕС НАР ДОЛОО ХОНОГТ 250 МЯНГАН ФУНТ АВАХЫГ ХҮСЧ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

*Английн "Арсенал" клуб энэ улиралд тун давгүй эхлэлийг тавьж, одоогоор хүснэгтийн гуравдугаар байрт бичигдэж байгаа билээ. Мөн багийн дасгалжуулагч Арсен Венгерийн "Арсенал"-д ирсний 20 жилийн ой саяхан тохиосон. Тиймээс энэ удаад "Арсенал" клубын эргэн тойрон дахь мэдээллийг хүргэж байна.*

### "Арсенал" Санчес, Өзилийн гэрээг сунгах уу

Английн "Арсенал" клубын хагас хамгаалагч Месут Өзил болон Алексис Санчес нар багтайгаа гэрээгээ сунгахад бэлэн байгаа ажээ. Герман болон Чили хагас хамгаалагчид "Арсенал"-тай 2018 он хүртэл гэрээтэй байгаа. Хэрвээ тэд үүнээс цааш гэрээгээ сунгаж тоглоно гэвэл долоо хоногт 250 мянган фунтын цалин авахыг хүсч буй юм байна. Уг нь тэд жилийн өмнө урьдчилсан байдлаар хэлэлцээр хийхдээ багаасаа 180 мянга орчмыг долоо хоногт авна гэж байж. Гэвч одоо 70 мянгаар илүү цалин авах хүсэлтэйгээ илэрхийлж эхэлжээ. Хэрвээ "Арсенал" Санчес болон Өзил нарын гэрээг сунгахаар шийдвэл анх төлөвлөснөөсөө 36 сая фунтээр илүү мөнгийг жилдээ зарцуулах хэрэгтэй болох юм байна. Энэ улирлын эхэнд "Арсенал" тун муугүй амжилтыг үзүүлж, одоогоор гуравдугаар байрт бичигдэж байгаа юм. Эхний долоон тойргийн дараах байдлаар тав хожиж, нэг тэнцэж, нэг хожигдсон амжилттайгаар 16 оноотой явж байна. Ингэснээр тэргүүлэгч "Сити"-гээс ердөө л хоёр оноо дутуу байгаа юм. Долоо тоглохдоо 16 гоол оруулж, есийг алдсан. Харин премьер лигт багийн мэргэн буучаар хагас хамгаалагч Алексис Санчес бичигдэж байна. Тэрбээр долоон тойрогт дөрвөн гоол оруулж, мэргэн буучийн жагсаалтын гуравдугаар эгнээнд жагсч яваа юм. Харин Өзилийн хувь дамжуулалтын хувиар дээгүүр байрт бичигдэж байна. Энэ хоёр тоглогч "Челси"-г 3:0-ээр буулгаж авахад хамгийн чухал гоолуудыг оруулсан. Багаа гуравдугаар байрт бичигдэх гол нөлөөг үзүүлж байгаа билээ.

### "Арсенал" Ивобигийн цалинг хоёр дахин нэмнэ

"Арсенал" клуб багийнхаа бас нэгэн хагас хамгаалагч Алекс Ивобигийн гэрээн шинэчлэх гэж байна. Өнгөрсөн дөрөвдүгээр сард Лондон хотын баг өдгөө 20 настай Негир эрийн цалинг долоо хоногийн 25 мянга болгож, шинэ гэрээ байгуулж байсан. Харин энэ улирал эхлээд Ивоби тогтмол гараанд гарч, тун сайн тоглолтыг үзүүлж байгаа. Тиймээс "Арсенал" дахин шинэ гэрээ байгуулж, түүний цалиг хоёр дахин нэмэгдүүлж, 50 мянган фунт болгохоор цэхэж байгаа ажээ. Одоогоор Ивоби "Арсенал"-ын төлөө премьер лигт таван тоглолтод оролцож, гурван гоолын дамжуулалт өгчихөөд байна.

### "Арсенал" Андре Силваг сонирхож эхэлжээ

Португалын "Порто" клубын довтлогч Андре Силваг "Арсенал" клуб сонирхож эхэлжээ. О Jogo-гийн мэдээлж байгаагаар Лондоны багийн скаутууд "Порто" клубыг Аваргуудын лигт "Лестер"-тэй тоглох үеэр түүний ямархуу авьяастайг үзэж, сонирхсон юм байна. "Порто" өнгөрсөн наймдугаар сард Андре Силвагийн гэрээг 2021 он хүртэл сунгаж, 60 сая еврогоор зарах тухай заалтыг ч оруулж өгсөн аж. Тэрбээр Португалын лигт долоо тоглолтод энэ улиралд гарч, таван гоол оруулж, нэг оновчтой дамжуулалт өгөөд байгаа юм байна.



## Месси "Манчестер Сити"-гийн эсрэг тоглоно

Испанийн алдарт "Барселона" багийн довтлогч Лионель Месси бэртэл авсны улмаас сүүлийн хэдэн тоглолтыг өнжөөд байгаа билээ. Түүнийг эзгүйд баг нь "Сельта" клубын талбайд 4:3-аар хожигдсон. Мөн тэрбээр 2018 оны дэлхийн аваргын урьдчилсан шатанд Аргентины шигшээд тоглох боломжгүй болсон. Тэгвэл Месси өчигдрөөс багийнхантайгаа хамт бэлтгэл хийж эхэлсэн байна. Гэхдээ ганцаарчилсан бэлтгэл хийж буй ажээ. "Барса" энэ сарын 19-нд Аваргуудын лигт "Манчестер Сити"-тэй тулна. Энэ чухал тоглолтод Месси оролцох юм байна.

## "Атлетик" клуб "Челси"-гээс 40 саяыг нэхэж байна

Испанийн "Атлетик Бильбао" клубын хагас хамгаалагч Оскар Де Маркосыг ирэх өвлийн солилцоо наймааны цонхоор Английн "Челси" авахаар төлөвлөж байгаа билээ. El Desmarque-ийн мэдээлж байгаагаар өдгөө 27 настай, хамгаалалт болон жигүүрт болоод төвд тоглох чадвартай, довтолгоо сайн дэмждэг супер тоглогчийг Лондоны баг авч, дөрвөн жилийн гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа аж. Харин "Атлетик" түүний төлөө 40 саяас доошгүй мөнгө нэхэж буй ажээ. Ийм хэмжээний мөнгөөр зарах талаар түүний гэрээнд ч заасан байгаа юм байна. Өнгөрсөн зургадугаар сард "Атлетик" түүнтэй гэрээгээ сунгаж, 2019 он хүртэл тоглуулахаар болохдоо ийм заалт багтаажээ. Де Маркос Ла лигт энэ улирал эхлээд зургаан тоглолтод оролцож, нэг гоолын дамжуулалт өгөөд байгаа юм байна.



# СПОРТ

ДУУЛГАХ СОНИН

## Д.Сумъяа, М.Уранцэцэг нар дэлхийн чансааг тэргүүлж байна



Н.ПУНЦАГБОЛД

Олон улсын жудо бөхийн холбооноос энэ сарын 2-ны өдөр жүдочдын шинэчилсэн чансааг гаргасан. Зуны олимпийн наадмын дараа гарч байгаа чансаа учраас багагүй өөрчлөлт орсон юм. Тэгвэл шинэчилсэн чансаа гарсны дараа манай хоёр бөх дэлхийн шилдгүүдийг тэргүүлсэн хэвээр үлдлээ. Тодруулбал, эмэгтэйчүүдийн 48 кг-ын жинд МУГТ, дэлхийн аварга М.Уранцэцэг дэлхийн чансааг тэргүүлсэн хэвээр үлдлээ. Манай бөх хэдийгээр Риогийн Олимпийн наадмаас медаль авч чадалгүй, шагналт тавдугаар байр эзэлсэн ч оноогоор гүйцэгдээгүй.

Харин 57 кг-д Гавьяат тамирчин Д.Сумъяа Олимпийн наадмаас мөнгөн медаль авсан учир оноогоо улам ахиулж, дэлхийн чансааны тэргүүнд хэвээр үлдсэн юм. Эрэгтэйчүүдээс 66 кг-д Д.Төмөрхүлэг хоёр, Д.Алтансүх дөрөвдүгээр байрт бичигдэж байна. Эрэгтэйчүүдээ дэлхийн чансааны эхний гуравт хамгийн олон бөхөө багтаасан нь Солонгос. 60, 66-г Өмнөд Солонгосынхон тэргүүлж байгаа бол 73, 90 кг-д эхний гуравт багтлаа. Харин Японы хүчирхэг шигшээ баг ердөө ганцхан 90 кг-д дэлхийн чансааг тэргүүлж байгаа юм. Тэгвэл дэлхийн чансааг тэргүүлж байгаа тамирчдаас хамгийн өндөр оноотой нь Америкийн Кайла Харрисон байна. Тэрбээр 4370 оноо цуглуулсан. Харин Тина Трсинжак 4050 оноотой байгаа бол Д.Сумъяа 3150 оноотой болжээ. Алдарт Тедди Ринер гэхэд 3250 оноотой явна. Ингээд аль жинд дэлхийн чансааг ямар бөх тэргүүлж байгаа болоод манай тамирчид хэддүгээрт бичигдэж буйг сонирхуулъя.

**Эрэгтэйчүүд**

**60 кг-д**

1 Ким Вон Жин 2310 /Өмнөд Солонгос/
2 Орхан Сафаров 2168 /Азербайжан/
3 Елдос Сметов 2003 Казахстан
5 Д.Амартүвшин 1796 /Монгол/
9 Г.Болдбаатар 1393 /Монгол/
22 Ц.Цогтбаатар 786 /Монгол/

**66 кг-д**

1 Ан Баул 3180 /Өмнөд Солонгос
2 Д.Төмөрхүлэг 2470 /Монгол/
3 Фабио Васели 1638 /Итали/
4 Д.Алтансүх 1620 /Монгол/

**73 кг-д**

1 Рустам Оружав 2930 /Азербайжан/
2 Ан Чан Рим 2580 /Өмнөд Солонгос/
3 Шёохэй Оно 2050 /Япон/
9 Г.Одбаяр 1360 /Монгол/
18 С.Ням-Очир 950 /Монгол/

**81 кг**

1 Хасан Халмарзаев 2392 /Орос/
2 Таканорэ Нагасэ 2151 /Япон/
3 Авдантили Тчрикишвили 2060 /Гүрж/
10 Н.Дагвасүрэн 1330 оноотой /Монгол/
18 О.Ууганбаатар 970 /Монгол/

**90 кг**

1 Мацу Бейкер 3030 оноотой /Япон/
2 Гвак Дон Хан 2290 /Солонгос/
3 Варлам Липартелиани 2282 /Гүрж/
6 Л.Отгонбаатар 1660 /Монгол/

**-100 кг-д**

1 Элмар Гасимов 2744 /Азербайжан/
2 Марет Курайли 2502 /Франц/
3 Крпалик Лукас 2420 /Чех/
18 Н.Түвшинбаяр 1035 /Монгол/

**+100 кг**

1 Тедди Ринер 3250 /Франц/
2 Хасаёши Харасава 2830 / Япон/
3 Сассон Ор 2004 /Израйль/
14 Б.Тэмүүлэн 1066 /Монгол/

**Эмэгтэйчүүд**

**48 кг**

1 М.Уранцэцэг 2705 /Монгол/
2 Паула Парета 2540 /Аргентин/
3 Г.Отгонцэцэг 2202 /Казахстан/

**52 кг**

1 Мажлинда Келменди 3150 /Косова/
2 Андрей Читу 2250 /Румын/
3 Мисато Накамура 2210 /Япон/
...18 А.Цолмон 900 /Монгол/
19 М.Бундмаа 898 /Монгол/

**57 кг**

1 Д.Сумъяа 3550 /Монгол/
2 Ким Жан Ди 2349 /Өмнөд Солонгос/
3 Рафаэль Сильва 2253 /Бразил/

**63 кг**

1 Тина Трсинжак 4050 /Словен/
2 Кларисса Агбегнэноу 2490 /Франц/
3 Мику Таширо 2020 /Япон/
...12 Ц.Мөнхзаяа 1192 /Монгол/
13 Ц.Цэрэннадмид 1152 /Монгол/

**70 кг**

1 Ким Поллинг 2433 /Недерланд/
2 Лаура Варгас Кох 2272 /Герман/
3 Харука Тачимото 2200 /Япон/
...16 Ц.Наранжаргал 1134 /Монгол/

**78 кг**

1 Кайла Харрисон 4370 /АНУ/
2 Одри Тчиумио 2790 /Франц/
3 Гусие Стинхуис 2494 /Недерланд/
...18 П.Лхамдэгд 871 /Монгол/

**+78 кг**

1 Идалус Ортиз 3146 /Куба/
2 Сон Юү 2930 /Хятад/
3 Эмилли Эндиол 2487 /Франц/
...30 534 /Монгол/

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 2
Шөнө -8

Нөгөөдөр
Өдөр 4
Шөнө -6

Өдрийн зурхай

**Намрын адаг шар нохой сарын Зургаан цагаан мэнгэтэй Хар нохой өдөр. Сугар гараг**

**Үс засуулбал:** Өнгө зүс сайжирна

**Наран ургах, шингэх:** 07:07 - 18:30



*Өдрийн өнгө: Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахайболой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.*

СПОРТЫН МЭДЭЭ

## Ц.Оюунчимэг ДАШТ-ээс мөнгөн медаль авлаа

Хүндийг өргөлтийн Мастерсын ДАШТ Герман улсад боллоо. 47 орны 987 тамирчин өрсөлдсөн тус тэмцээнд манай улсаас гурван туйванч оролцсоноос Ц.Оюунчимэг мөнгөн медаль авлаа. Эмэгтэйчүүдийн +75 кг-д өрсөлдсөн тэрээр огцом шахалтаар 55, түлхэлттэй өргөлтөөр 78 кг, нийлбэрээр133 кг өргөж мөнгөн медалийн болзол хангав. Түүний жинд 14 тамирчин өрсөлджээ. Ц.Оюунчимэг мастерсын ДАШТ, Дэлхийн цом, гран при тэмцээний хошой аварга, дэлхийн рекордыг эзэмшдэг, ОУХМ цолтой. 49 настайгаасаа хойш хүндийг өргөлтөөр хичээллэж буй тэрбээр ДАШТ-ий рекордыг зургаа, Азийнхыг 12 удаа шинэчилсэн.

## Д.Алтансүх хагас шигшээд шалгарав



Жүдо бөхийн Ташкентын гран при тэмцээн өнөөдөр эхэллээ. 15 орны эрэгтэй 81, эмэгтэй 58 жүдоч өрсөлдөж буй тус тэмцээнд манай улсаас эх орноо төлөөлөн хоёр тамирчин зодоглож байна. Дөнгөж сая эрэгтэйчүүдийн 66 кг-д зодоглож буй ОУХМ Д.Алтансүх Азербайжаны бөхийг ялж, хагас шигшээд шалгарлаа. Тэрээр эхний тойрогт гоц мөргөсөн юм. Д.Алтансүх мөнгөн медалийн төлөө Япон, Беларусь улсын бөхчүүдийн аль ялсантай нь барилдана.

## Т.Санчир "SBL Хасын хүлгүүд" багт дахин тоглоно



Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчин, ОУХМ Тунгалагийн Санчир "SBL Хасын хүлгүүд" багт эргэн нэгдлээ. Тэрбээр 2012-2014 оны хооронд тус багт тоглож байсан билээ. Улмаар 2014 онд Үндэсний супер лигийн аваргын цом өргөсөн юм. Харин "SBL Хасын хүлгүүд"-д эргэн ирэхээсээ өмнө "Баянгол Сэнтоза Ирвэсүүд" багт хүчин зүтгэж байсан юм. Өдгөө 27 настай тэрээр өнгөрсөн онд Филлипинийн дээд лигийн "Barangay Ginebra San Miguel" багт тоглосон. Т.Санчир "Инчён-2014" Азийн наадмын үеэр 16.6 оноо, 5.6 самбараас бөмбөг авалт дунджилж, тив, дэлхийн энтэй сагсчин болохоо нотолсон юм.


ТЭНГИС КИНО ТЕАТР




Риогийн олимпиос мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргасан жүдоч Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэн бүтээв.




Жэкоб хүүд нэгэн захиа ирсний дагуу нууцлаг арал дээр очно. Тэнд төрөл бүрийн өвөрмөц чадвартай хүүхдүүд амьдардаг Хадагтай Перегриний өвөрмөц хүүхдийн ордон байлаа.




"Deepwater Horizon" нь найруулагч Peter Berg-н найруулсан, Deepwater Horizon хэмээх өрмийн цамхгийн сүйрлийн бодит түүхээс сэдэвлэсэн бүтээл юм.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ




Гарах хугацаа 2016.10.07




Гарах хугацаа 2016.10.13




Гарах хугацаа 2016.10.14




Гарах хугацаа 2016.10.20




Гарах хугацаа 2016.10.28